



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ
УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА



Улаанбаатар
2022 он



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



International
Labour
Organization



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ
УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН
ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Улаанбаатар
2022 он



Шаардлагатай эшлэл:

НҮБ-ын ХХААБ. 2022. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ингэний Сүүн Бүтээгдэхүүний Зах Зээлийн Судалгаа. Улаанбаатар хот.

Энэхүү мэдээллийн бүтээгдэхүүнд ашигласан нэр томьёо, материалын танилцуулга нь аливаа улс орон, газар нутаг, хот, тэдгээрийн эрх бүхий байгууллага, эсхүл тэдгээрийн хил, хязгаарыг тогтоох тухай хууль эрх зүйн болон хөгжлийн байдлын талаар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ) эсвэл Европын Холбоо (ЕХ)-ны аливаа үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Тодорхой компани, үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг патентлагдсан эсэхээс нь үл хамааран уг мэдээллийн бүтээгдэхүүнд дурдсан нь бусад дурдаагүй ижил төстэй шинж чанар бүхий бүтээгдэхүүнээс тэдгээрийг НҮБ-ын ХХААБ эсвэл Европын Холбооноос илүүд үзсэн, эсвэл санал болгосон гэсэн уг биш юм.

Энэхүү мэдээллийн бүтээгдэхүүнд тусгагдсан үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд НҮБ-ын ХХААБ эсвэл Европын Холбооны үзэл бодол, бодлогыг тусгасан гэсэн уг биш юм.

© НҮБ-ын ХХААБ, 2022



Зарим эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү бүтээлийг Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 3.0 IGO лицензийн дагуу (CC BY-NC-SA 3.0 IGO; <https://creativecommons.org/licenses/by-nc-sa/3.0/igo>) ашиглах боломжтой.

Энэхүү тусгай зөвшөөрлийн нөхцөлийн дагуу уг бүтээлийг зохих ёсоор иш татсан тохиолдолд арилжааны бус зорилгоор хуулбарлах, дахин түгээх, өөрчлөх боломжтой. Уг бүтээлийг ашиглахдаа НҮБ-ын ХХААБ-аас ямар нэгэн тодорхой байгууллага, бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмждэг гэсэн санаа байх ёсгүй. ХХААБ-ын логог ашиглахыг хориглоно. Хэрэв уг бүтээлийг тохируулан ашиглахаар бол ижил эсвэл түүнтэй адилтгах Creative Commons лицензийн дагуу лицензтэй байх ёстой. Хэрэв энэ бүтээлийг орчуулсан бол шаардлагатай эшлэлийн хамт дараах мэдэгдлийг агуулсан байх ёстой: «Энэ орчуулгыг НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO) хийгээгүй болно. ХХААБ нь энэхүү орчуулгын агуулга, үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй. Англи хэл дээрх эх хэвлэл нь эрх бүхий хэвлэл байна.»

Тусгай зөвшөөрлийн талаар үүссэн маргаантай холбоотой аливаа эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон Улсын Худалдааны Хуулийн Хорооны (UNCITRAL) одоогийн мөрдөж буй Арбитрын журмын дагуу явуулна.

Гуравдагч талын материалын талаар. Хүснэгт, зураг, дүрс гэх мэт гуравдагч этгээдтэй холбоотой материалыг дахин ашиглахыг хүссэн хэрэглэгчид дахин ашиглах зөвшөөрөл шаардлагатай эсэхийглавлан тодруулж, зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авах үүрэгтэй. Бүтээлийн гуравдагч этгээдийн эзэмшлийн аливаа бүрэлдэхүүний хэсгийг зөрчсөнөөс үүсэх нэхэмжлэлийн эрсдэлийг зөвхөн хэрэглэгч хариуцна.

Борлуулалт, эрх, лиценз. ХХААБ-ын мэдээллийн бүтээгдэхүүнийг НҮБ-ын ХХААБ-ын веб сайт (www.fao.org/publications)-аас авах боломжтой бөгөөд publications-sales@fao.org хаягаар холбогдон худалдан авч болно. Арилжааны зориулалтаар ашиглах хүсэлтийг www.fao.org/contact-us/licence-request хаягаар илгээнэ. Эрх, лицензтэй холбоотой хүсэлтийг copyright@fao.org хаягаар илгээнэ үү.

ТАЛАРХАЛ

“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол Улсын Засгийн газартай хамтран Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Уг төслийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд ХХААБ нь давуу талынхаа хүрээнд техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна. Дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний судалгаа хийх, технологи хөгжүүлэхэд сонирхогч талуудтай хамтран ажиллаж буйн нэг нь ингэний сүүн шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд холбогдох талуудтай хамтран ажиллаж буй явдал юм.

Энэ хүрээнд Монгол ингэний сүүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх боломжийг нээх зорилгоор энэхүү судалгааг ХХААБ-ын захиалгаар БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны ХЯТАД-КАЗАКСТАН тэмээ судлалын хүрээлэн хийж гүйцэтгэсэн юм.

Судалгааны тайланг Монгол хэл рүү хөрвүүлснийг Монгол улсын Зөвлөх инженер, НҮБ-ын ХХААБ-ын Агри-бизнесийн түншлэл хариуцсан мэргэжилтэн агсан Бямбын Мөнхжаргал хянан тохиолдуулж олноо хүргэхэд бэлэн болгосонд гүнээ талархал илэрхийлж байна.



АГУУЛГА

1. Оршил: БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ	6
2. БНХАУ-ЫН ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН ТОЙМ.....	9
2.1. БНХАУ-ЫН ТЭМЭЭН СҮРГИЙН ТАРХАЛТ БА ХҮН АМЫН ТАРХАН СУУРЬШИЛТ	10
2.2. БНХАУ дахь тэмээн сүргийн үүлдэр.....	11
2.3. Ингэний сүүн бүтээгдэхүүний төрлүүд.....	14
3. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	16
3.1. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ	17
3.2. БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгчид.....	17
3.3. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨСӨЛТ	18
3.4. Ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг зардал ба үнэ	20
3.5. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ.....	23
3.6. БНХАУ-Д ТАНИГДСАН ИНГЭНИЙ СҮҮНИЙ БРЭНД БУЮУ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН	24
3.7. Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи.....	25
3.8. Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж.....	30
4. БНХАУ дахь хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаа.....	33
4.1. БНХАУ-ЫН СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА	35
4.2. АМТ ШИМТИЙН СОНГОЛТ БУЮУ ХҮСЭЛ СОНИРХОЛ	36
4.3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ	36
5. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА	38
5.1. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЗӨРҮҮ	39
5.2. Ингэний сүүний хэрэглээ (эрэлт, нийлүүлэлт)-НИЙ 2022-2027 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ БА ӨСӨЛТИЙН ХУВЬ.....	41
5.3. Гол сорилт бэрхшээлүүд.....	42
6. Импортын бодлого.....	45
6.1. Ингэний сүүн бүтээгдэхүүнд мөрдөгддөг БНХАУ-ЫН СТАНДАРТ БА ДЭГ ЖУРАМ.....	46
6.2. Ложистикт тавигддаг даатгалын гэрээний нэмэлт үүргийн шаардлага	48
6.3. Экспортод учирч болзошгүй эрсдэлүүд ба тэдгээрийг даван туулах арга зам.	49
6.4. Монгол Улсаас БНХАУ руу ингэний сүү экспортлох маршрут.....	52
7. Дүгнэлт.....	58
8. Хавсралт	61
Хавсралт 1. БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгчид	62
Хавсралт 2. БНХАУ-Д ТАНИГДСАН ИНГЭНИЙ СҮҮНИЙ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН	76
Хавсралт 3. Экспортын баримжаатай ингэний сүүн бүтээгдэхүүнд мөрдөгддөг БНХАУ-ЫН СТАНДАРТУУД БОЛОН ДҮРЭМ ЖУРАМ.....	133
Хавсралт 4. БНХАУ болон олон улсын худалдаа, гаалийн нөхцөл, шаардлагууд.....	133
Хавсралт 5. БНХАУ-ЫН ИМПОРТ, ЭКСПОРТЫН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	141
Хавсралт 6. ХЯТАД-МОНГОЛЫН ХИЛИЙН БООМТ, ТЭДГЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС БОЛОН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРООНДЫН ХЭЛЭЛЦЭЭР	155

Зураг

Зураг 1.	Сүүлийн 10 жилд БНХАУ-ын тэмээн сүргийн тоо толгойд орсон өөрчлөлт.....	10
Зураг 2.	Гол тархац нутаг дахь тэмээн сүргийн тоо толгойд орсон өөрчлөлт.....	11
Зураг 3.	БНХАУ-ын тэмээний үүлдрийн тархалт.....	11
Зураг 4.	Алшагийн хос бөхт тэмээ	12
Зураг 5.	Сөнөдийн хос бөхт тэмээ.....	12
Зураг 6.	Чинхайн хос бөхт тэмээ	13
Зураг 7.	Таримын хос бөхт тэмээ	13
Зураг 8.	Зүүнгарын хос бөхт тэмээ	14
Зураг 9.	БНХАУ дахь сүүн бүтээгдэхүүний зах зээлийн борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр), 2016-2021 он.....	17
Зураг 10.	Ингэний сүүний томоохон үйлдвэрлэгчдийн тархалт	18
Зураг 11.	Ингэний сүүн бүтээгдэхүүний төрлүүд	18
Зураг 12.	Ингэний сүүн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд эзлэх хувь.....	19
Зураг 13.	БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин	19
Зураг 14.	Цахим худалдааны платформоор борлуулсан ингэний сүүн бүтээгдэхүүний эзлэх хувь.....	20
Зураг 15.	БНХАУ дахь ингэний түүхий сүү худалдан авах үнийн төлөв хандлага.....	20
Зураг 16.	Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний өртөг зардлын бүтэц	21
Зураг 17.	Янз бүрийн сувгаар борлуулсан ингэний сүүн бүтээгдэхүүний үнийн дээд, доод хязгаар	22
Зураг 18.	БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлт	23
Зураг 19.	Цахим худалдааны платформоор дамжуулж хийсэн БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт.....	23
Зураг 20.	БНХАУ-ын томоохон цахим худалдааны платформоор худалдан борлуулсан ингэний сүүн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин.....	24
Зураг 21.	Шингэн сүү үйлдвэрлэлийн дарааллыг харуулсан график дүрслэл.....	26
Зураг 22.	Шингэн сүү үйлдвэрлэлийн шугамын зураг.....	27
Зураг 23.	Хуурай сүү үйлдвэрлэлийн дарааллыг харуулсан график дүрслэл	28
Зураг 24.	Хуурай сүү үйлдвэрлэлийн шугамын зураг	28
Зураг 25.	Хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлж буй хүчин зүйлс.....	34
Зураг 26.	Ингэний сүүн бүтээгдэхүүний дэлхийн нийт борлуулалт	39
Зураг 27.	БНХАУ-ын ингэний сүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү.....	40
Зураг 28.	Дэлхийн болон БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн харьцуулалт, 2021 он.....	41
Зураг 29.	Улсын хэмжээний ингэний сүүний хэрэглээ, хэрэглээний өсөлтийн төсөөлөл, 2022-2027 он.....	42
Зураг 30.	Улсын хэмжээний ингэний сүүний хэрэглээ, хэрэглээний өсөлтийн төсөөлөл, 2022-2027 он.....	50

Хүснэгт

Хүснэгт 1.	Ингэний цэвэр хуурай сүүний томоохон брэндүүдийн жижиглэнгийн үнэ	22
Хүснэгт 2.	Ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ба гол параметрүүд	31
Хүснэгт 3.	Зохицуулалт, удирдлагын аргыг хавсралтаар үзүүлсэн нь.....	47
Хүснэгт 4.	Сүү, сүүн бүтээгдэхүүний эрсдэлийн зэрэглэл.....	49
Хүснэгт 5.	БНХАУ, Монгол Улсын хилийн боомтууд.....	53

1

ОРШИЛ: БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



21-р зуунаас эхлэн ингэний сүүний үйлдвэрлэл хөгжин, шинэчлэгдэж, хэрэглэгчдийн эрүүл мэндийн мэдлэг дээшилж, хүнсний хэрэглээнд зарцуулах орлогын чадавх сайжирсан зэрэг нь дэлхийд ингэний сүүний эрэлт хэрэгцээ хурдацтай нэмэгдэхэд тулхэц өгсөн бөгөөд БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ сүүлийн таван жилд гэхэд асар хурдацтай өсжээ. Энэхүү тайланг БНХАУ-ын ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд иж бүрэн судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр бэлтгэсэн болно.

САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТОЙМ

- Сүүлийн 5 жилд Хятадын ингэний сүүний зах зээлийн жилийн дундаж өсөлт **5.53%**-тай байв.
- Түүхий сүүний нийлүүлэлт дутагдалтай байгаа ба импортын хэрэгцээ **470 мянган тоннд** хүрсэн.
- Зах зээл дээр бүх нэр төрлийн сүүн бүтээгдэхүүн борлуулдаг, гэдээ ингэний хуурай сүү уг зах зээлийн **68%**-ийг эзэлж байна.
- Борлуулалтад жижиглэнгийн дэлгүүрүүд давамгайлсан хэвээр хэдийч, цахим борлуулалт хурдацтай буюу **300 хүртэлх хувиар** өссөн.



- Сүүний эх үүсвэрийн бааз суурийг нэмэгдүүлэх**, сүү, цагаан идээний чанараг сайжруулах, тухайлсан хувь хүмүүст зориулсан болон төрөлжсөн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох, хөгжүүлэх
- Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх**, хэрэглэгчдийн бүтээгдэхүүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг сэргээх
- Маркетингийн сувгуудыг бий болгох, санаачилга гаргаснаар хуваарилалтын ложистик болон маркетингийн зардлыг бууруулах боломжтой.**

СОРИЛТ БЭРХШЭЭЛ БА БОЛОМЖ

БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээлийн хөгжлийн судалгааны гол агуулгыг дараах байдлаар хураангуйлаа. Үүнд:

Үйлдвэрлэлийн цар хүрээ ба өсөлтийн хувь:

2021 оны эцэс гэхэд, БНХАУ-ын тэмээн сургийн тоо толгой 424700-д хүрч, жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Өнгөрсөн 5 жилд БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээл жилд дунджаар 5.5 хувиар өссөн бөгөөд хурдацтай өсөлт хадгалагдсан хэвээр байна. 2021 онд БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийт борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 751.3 сая ам.долларт хүрсэн бөгөөд зах зээлийн эрэлтийн өсөлт Европ, Африк, Ази тивийн бусад орнуудтай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байгаа ба цаашид ч зах зээлийн өсөлтийн томоохон орон зайд байсаар байх төлөв ажиглагдаж байна. Ойрын хэдэн жилд ингэний сүүн бүтээгдэхүүний хэрэглээ үргэлжлэн нэмэгдэнэ. Дотоодын зах зээлд наад зах нь 470000 тонн ингэний сүүний эрэлт хэрэгцээ байна гэсэн тооцоо бий.

Зах зээлийн төвлөрөл ба брэнд хөгжүүлэлт:

Одоогийн байдлаар, БНХАУ-д, гол төлөв Өвөр Монгол, Шинжианд төвлөрсөн 100 гаруй ингэний сүүний аж ахуй бүртгэлтэй бөгөөд 3000 гаруй ингэний сүүний брэнд дэлгүүр ажилладаг. Нийт ингэний сүүний зах зээлийн 68 хувийг ингэний хуурай сүү эзэлж байна.

Өртөг зардал ба үнэ:

Ингэний сүүний үйлдвэрлэлийн өртөг зардал үнээний сүүтэй харьцуулахад 10 дахин өндөр. 2021 оны байдлаар, 1 кг ингэний түүхий сүүний татан авалтын үнэ 25 юань, 1 кг шингэн сүү 200-300 юаниар худалдаалагдаж байв. Ингэний янз бурийн брэндийн



хуурай сүүний үнэ хоорондоо асар их ялгаатай. Хамгийн томоохонд тооцогдох 10 брэндийн 1 кг хуурай сүүний дундаж үнэ 1989 юань байна.

Борлуулалтын сувгийн өөрчлөлт ба өнөөгийн нөхцөл байдал:

Өнөөгийн байдлаар, үнэ өртөгхямд, хэрэглэхэд дөхөм, хурдан үйлчлүүлэх боломжтой зэргээс шалтгаалан ингэний сүүн бүтээгдэхүүний цахим худалдаа хурдацтай өсөж байгаа ч, борлуулалтад жижиглэн худалдааны дэлгүүрүүд давамгайлсан хэвээр байна. 2021 онд ингэний цэвэр хуурай сүүний цахим борлуулалт 300 хувиар өсөж, нийт борлуулалтын 16 хувьтай тэнцсэн бөгөөд цаашид ч нэмэгдэх орон зайд бий. Ингэний сүүн бүтээгдэхүүнийг гол төлөв Taobao, JD.COM, Tik Tok, Kwai шууд нэвтрүүлэг зэрэг платформоор дамжуулан борлуулж байгаагаас 64 хувийг Taobao-оор дамжуулж хийсэн борлуулалт эзэлж байна.

БНХАУ-ын ингэний сүүний зах зээл өнөөгийн шатанд хэдийгээр сайн хөгжиж байгаа ч, олон тооны сорилт бэрхшээлтэй тулгарч ирсэн. Дараагийн шатанд дор дурдсан гол сорилт бэрхшээлүүдтэй тулгарахаар байна. Үүнд:

Ингэний сүүн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах:

Ингэний сүүг голчлон сүү, цагаан идээ боловсруулдаг аж ахуй эрхлэгчид, фермерүүд, хоршоо болон бусад аж ахуй эрхлэгчид үйлдвэрлэдэг бөгөөд тэдний хувьд сүүний найрлага дахь уураг, тос, соматик эсийн тоо, түүхий сүүн дэх нийт бактерийн нийт тоо зэрэг физик, химийн үзүүлэлтүүдийг тооцооход хүндрэлтэй байдаг. Хэдийгээр, сүүний суурь бааз томоохон хөрөнгө оруулалт шаарддаг, бүтээн байгуулалтын хугацаа урт, богино хугацаанд ашигт ажиллагааг хангах боломж тааруу боловч, сүүний эх үүсвэрийг бий болгож, активын бүтцийг өөрчилж, нийлүүлэлтийн баттай шугамыг бий болгон, бүтээгдэхүүнийг өвөрмөц шинж чанартай болгох, төрөлжүүлэх инновац хийснээр тэмээний аж ахуйг илүү урт хугацаандаа тасралтгүй, тогтвортой байдлаар хөгжүүлэх боломжтой.

Сүүн бүтээгдэхүүний хэрэглээг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх:

Ингэний сүүн бүтээгдэхүүний онцлог шинж чанарыг сурталчлах ажлыг цаашид эрчимжүүлэх шаардлагатай. Ингэний сүүний тэжээллэг чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдлыг олон хэлбэрээр хэрэглэгчдэд сурталчлан таниулах, ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний талаарх хэрэглэгчдийн санаа бодол, хүсэлт шаардлагыг мөн ойлгож авах нь зүйтэй. Өргөн хүрээг хамарсан сурталчилгаа хийх, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бид хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлж, ингэний сүүн бүтээгдэхүүний хэрэглээг өдөөж, тэмээний аж ахуйн эрүүл хөгжлийг дэмжих боломжтой.

Маркетингийн сувгуудыг бий болгож, шинэлэг болгох:

Үйлдвэрлэлийн хэмжээ багаас шалтгаалан, ингэний сүүний үнэ үнээний сүүнээс мэдэгдэхүйц өндөр байна. Өнөөгийн байдлаар, сүүний үйлдвэрүүдийн логистик, түгээлт, борлуулалт, маркетингийн зардал нэмэгдсээр байгаа нь бүтээгдэхүүний өртөг зардал нэмэгдэхэд хүргэж байна. Борлуулалтын өртөг зардлын өсөлт аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхолд нөлөөлөөд зогсохгүй, мөн хэрэглэгчдийн эрх ашгийг хохироож байна. Логистик, түгээлтийн үйлчилгээний иж бүрэн платформ болон маркетингийн сувгуудыг бий болгож, инновац шингээснээр логистик, түгээлт, маркетингийн зардлыг үр дүнтэй бууруулах боломжтой.

2


БНХАУ-ЫН ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН ТОЙМ

- 2.1. БНХАУ-ын тэмээн сүргийн тархалт ба хүн амын тархан суурьшилт
- 2.2. БНХАУ дахь тэмээн сүргийн үүлдэр
- 2.3. Ингэний сүүн бүтээгдэхүүний төрлүүд



2.1. БНХАУ ДАХЬ ТЭМЭЭН СҮРГИЙН ТАРХАЛТ БА ПОПУЛЯЦИ


БНХАУ нь дэлхийн хос бөхт тэмээ үргүүлгийн гол бүс нутгийн нэг юм. 2021 оны эцэст, БНХАУ-д нийт 424700 тоо толгой хос бөхт тэмээ тоологдонон дийлэнх нь Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО), Шинжиан-Уйгурын Өөртөө Засах Орон (ШУӨЗО), Ганьсу муж болон Чинхай буюу Хөхнуур мужид тоологдсон бөгөөд ингэний сүүний үйлдвэрлэл хөгжих хэрээр тэмээн сүргийн тоо толгой (Зураг 1-д үзүүлсэнчлэн) жил ирэх тусам өссөөр байна.



Зураг 1. Сүүлийн 10 жилд тэмээн сүргийн тоо толгойд орсон өөрчлөлт

Өвөр Монголын тэмээ голдуу Алша аймаг, Баяннуур хот, Вуланчабу хот, Шилийн гол аймагт тархсан байдаг. ӨМӨЗО-ны тэмээн сүргийн тоо толгой зүүнээс баруун тийш аажмаар нэмэгддэг бөгөөд баруун зүгийн Алша аймаг нь тэмээн сүргийн хамгийн төвлөрсөн бүс нутаг юм. Шинжианд ч мөн тэмээ өргөн тархсан бөгөөд Алтай, Тачэн, Или, Аксу, Каши, Хотан, Хами зэрэг тойрог болон тойргийн түвшний хотуудад голдуу тархсан. Шинжианы умард нутгийн тэмээний тоо толгой өмнөд Шинжиантай харьцуулахад илүү ихээр төвлөрөх хандлагатай байна. Чинхай буюу Хөхнуур мужийн тэмээ голдуу Хайши Монгол - Төвдийн Өөртөө Засах Тойргийн нутагт төвлөрч тархсан. Ганьсу мужийн Хэси коридорын зүүн хэсэг нь байгалийн сайхан нөхцөлтэй. Тэмээ сүрэг Жюцюань, Вувэй, Жанье зэрэг мужуудад голчлон Аксай Казакийн Өөртөө Засах Хошуу болон Сүбэй Монголын Өөртөө Засах Хошуунд тархсан байдаг.

Сүүлийн жилүүдэд Шинжиан болон ӨМӨЗО-ны тэмээн сүргийн тоо толгой жилээс жилд өсөж байгаа бол Ганьсу, Чинхайд тэмээний аж ахуй харьцангуй тогтвортой хөгжиж байна (Зураг 2-т харуулав). 2021 онд, тэмээн сүргийн тоо толгой Шинжианд 197600, Өвөр Монголд 180100, Ганьсуд 35000, Чинхайд 12,000-д хүрсэн. БНХАУ-ын нийт тэмээн сүргийн 46.5 хувь нь ШУӨЗО-д, 42.2 хувь нь ӨМӨЗО-нд ногдож байна.



Зураг 2. Гол тархац нутаг дахь тэмээн сүргийн тоо толгойд орсон өөрчлөлт

2.2. БНХАУ ДАХЬ ТЭМЭЭНИЙ ҮҮЛДРҮҮД

БНХАУ нь Алшагийн хос бөхттэмээ, Сөнөдийн хос бөхттэмээ, Тармийн хос бөхттэмээ, Зүүнгарын хос бөхттэмээ, Чинхайн хос бөхттэмээ гэсэн таван үүлдрийн тэмээтэй.



Зураг 3. БНХАУ-ЫН ТЭМЭЭНИЙ СҮРГИЙН ҮҮЛДРИЙН ТАРХАЛТ



2.2.1. Алшагийн хос бөхт тэмээ

Алшагийн хос бөхт тэмээн сүргийн гол тархац нутаг нь ӨМӨЗО-ны Бадайн Жаран цөл, Тэнгэр цөл, түүнчлэн, Алша аймгийн Баруун хошуу, Зүүн хошуу болон Эзний хошууны эргэн тойрны газар нутаг юм. Энэ нь зүүн талаараа Баяннуур, баруун талаараа Ганьсу мужийн Жючуань хотын харьяаны Сүбэй Монголын Өөртөө Засах Хошууны Мазонг уул хүртэл үргэлжилдэг. Мөн Аксай дахь Казакийн Өөртөө Засах Хошуу нутагт тархсан. 1981 онд Алшагийн хос бөхттэмээн сүргийн тоо толгой хамгийн олон буюу 307700-д хүрсэн түүхтэй.

Гэтэл байгаль экологийн доройтол, зах зээлийн нөлөөлөл болон бусад шалтгааны улмаас 2002 онд 61000 болж огцом буурсан бөгөөд харин 2010 оноос эхлэн ингэний сүүний үйлдвэрлэл хөгжихийн хэрээр Алшагийн хос бөхт тэмээн сүргийн тоо толгой жилээс жилд нэмэгдэж эхэлсэн. 2021 оны эцэст тэмээн сүргийн тоо толгой 157000-д хүрээд байна. Алшагийн ингэний саалийн хугацаа 14-16 сар бөгөөд нэг ингэнээс өдөрт дунджаар 2-3,5 литр сүү саадаг.



Зураг 4. Алшагийн хос бөхт тэмээ

2.2.2. Сөнөдийн хос бөхт тэмээ

Сөнөдийн хос бөхт тэмээ ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн нутаг болох Сөнөдийн зүүн болон баруун хошуу, түүнчлэн Бугат, Улаанцав, Хөх хот, Хөлөнбуйр, Түнляя буюу Байшинт, Чифен буюу Улаанхад орчимд голчлон тархсан. Одоогийн байдлаар Сөнөдийн хос бөхт тэмээн сүргийн тоо толгой 18000 орчим гэж тоологдоод байна. Нэг ингэнээс өдөрт дунджаар 1.5-2 литр сүү саадаг. 8-11 дүгээр сар хүртэл саалийн хэмжээ их буюу өдөрт 3.5 литр сүү саах боломжтой бөгөөд саалийн хугацаа 14 сар.



Зураг 5. Сөнөдийн хос бөхт тэмээ

2.2.3. Чинхайн хос бөхт тэмээ

Чинхайн хос бөхт тэмээ Кайдамын сав газарт тархсанаас үүдээд Чинхайн буюу Хөхнуурын хос бөхт тэмээ ч гэж нэрлэдэг болсон бөгөөд гол төлөв Кайдамын сав газрын Улаан, Дулаан, Голмуд хошуудын (хотууд) нутагт төвлөрдөг. Чинхайн хос бөхт тэмээн сүргийн тоо толгой 1980 оны эцэст 27400, 1992 онд 18500, 2005 онд 5400, 2015 онд 6700, 2021 онд 12000 байсан ба нэг ингэнээс өдөрт дунджаар 2-3.5 литр сүү саадаг.



Зураг 6. Чинхайн хос бөхт тэмээ

2.2.4. Тармийн хос бөхт тэмээ

Тармийн хос бөхт тэмээн сүргийн гол тархац нутаг нь Шинжааны Тармийн сав газрын зах бөгөөд голчлон Шинжааны өмнөд хэсгийн Аксу болон Баянгол-Монголын Өөртөө Засах Тойрог, Кашгар, Хотан, Аксу болон бусад бүс нутагт тархсан. Тармийн хос бөхт тэмээ Шинжааны нийт тэмээний 32 хувийг эзэлдэг бөгөөд саалийн хугацаа нь дунджаар 12 сар, нэг ингэнээс өдөрт дунджаар 1-2 литр сүү саадаг.



Зураг 7. Тармийн хос бөхт тэмээ

2.2.5. Зүүнгарын хос бөхт тэмээ

Зүүнгарын хос бөхт тэмээний тархалтын гол нутаг нь Шинжааны Хөх тохой хошуу, Тарвагатай хот, Мулей, Или, Алтай, Баликун, Иву сав газар юм. 2021 оны байдлаар, Зүүнгар үүлдрийн тэмээ Шинжааны нийт тэмээний 68 хувийг эзэлж байна.



Зүүнгарын ингэний сүүний гарц өдөрт дунджаар 2-2.4 литр, нэмэлт тэжээлээр бордсон тохиолдолд 4-5 литрт хүрдэг ба тэдгээрийн дотроос Мулейн ингэний сүүний гарц 4-5 литр байна.



Зураг 8. Зүүнгарын хос бөхт тэмээ

2.3. ТӨРӨЛ БҮРИЙН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

2.3.1. Ингэний хуурай сүү

Ингэний хуурай сүү нь ингэний түүхий сүүг гол түүхий эд болгон, түүний тослогийг бүрэн, эсхүл хэсэгчлэн багасгах, ариутгах, өтгөрүүлэх, хатаах болон үйлдвэрлэлийн бусад процессоор дамжуулан гаргаж авдаг нунтаг бүтээгдэхүүн юм. Уг бүтээгдэхүүн нь тэмээний сүүний өнгө, амтыг хадгалж, тэжээллэг чанарыг нь дээд зэргээр нэмэгдүүлээд зогсохгүй ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нь ч ихээхэн хэмжээгээр бүрдүүлдэг.



2.3.2. Ингэний сүүний боловсруулсан хуурай сүү

Ингэний сүүний боловсруулсан хуурай сүү нь ингэний хуурай сүү, эсвэл түүнээс гаргаж авсан сүүн бүтээгдэхүүнийг үндсэн түүхий эд болгон бусад түүхий эдийг нэмж, хүнсний нэмэлт, тэжээллэг болон баяжуулах бодис нэмж эсвэл нэмэхгүйгээр хуурай болон нойтон аргаар сүүний хуурай бодисыг агууламж 70 хувиас багагүй байхаар боловсруулсан нунтаг бүтээгдэхүүн юм. Ингэний сүүний боловсруулсан хуурай сүүг голчлон ингэний хуурай сүүний дуршлыг нэмэгдүүлэхийн тулд зарим тодорхой хэрэглэгчдэд тусгайлан зориулж үйлдвэрлэгдэг.



2.3.3. Ингэний эсгэсэн сүү буюу эсэг сүү

Ингэний эсгэсэн сүү нь ингэний түүхий сүүгээр эсгэсэн сүү, эсхүл сэргээсэн сүүг түүхий эд болгон, ариутгасны дараа pH-ийн утга багатай анхдагч буюу цэвэр өсгөврийн хөрөнгөөр эсгэсэн бүтээгдэхүүн юм. Ингэний эсгэсэн сүүнд пробиотик буюу ашигтай бактери агуулагддаг тул хүний гэдэсний бичил орчны тэнцвэрт байдлыг хадгалж, хоол боловсруулах үйл ажиллагааг сайжруулдаг.



2.3.4. Ингэний шингэн сүү

Ингэний шингэн сүүг ингэний түүхий сүүг түүхий эд болгон, сэргээсэн сүү нэмж, эсвэл нэмэхгүйгээр шингэн хэлбэрээр нь ариутган боловсруулалт хийсний дараа, асептик аргаар савлах болон бусад аргаар гаргаж авсан шингэн бүтээгдэхүүн бөгөөд ихэвчлэн хадгалах хугацаа богино байдаг.



2.3.5. Ингэний сүүн шахмал буюу үрлэн бүтээгдэхүүн

Ингэний сүүн шахмалыг ингэний түүхий сүүгээр, харин ингэний ааруулыг ингэний эсгэсэн сүүгээр хийдэг. Эдгээр бүтээгдэхүүн нь авч явахад хялбар бөгөөд амт сайтай.



2.3.6. Ингэний сүүн шоколад

Ингэний сүүн шоколад нь какаоны бүтээгдэхүүн болон/эсвэл цагаан элсэн чихэр агуулсан ингэний сүүн шоколадыг гол түүхий эд болгон, тасалгааны температурт хүнсний хатуу эсвэл хагас хатуу төлөвийг хадгалахын тулд тодорхой процессоор дамжуулан түүн дээр ингэний сүүн болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн нэмж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн. Зөөлөн амт, таатай үнэртэй байдаг.



2.3.7. Ингэний сүүн зайрмаг

Ингэний сүүн зайрмаг нь ундны ус, ингэний сүүгээр хийсэн болон/эсвэл ингэний сүүн бүтээгдэхүүн, өндөг, жимс, шар буурцгийн бүтээгдэхүүн, элсэн чихэр, ургамлын тос зэрэг нэг буюу хэд хэдэн түүхий эд, хүнсний нэмэлтийг нэмж, эсвэл нэмэхгүйгээр холих, ариутгах, жигдрүүлэх, хөргөх, болгох буюу ариутгах, хөлдөөх, хатууруулах болон хөлдөөсөн ундааны хэмжээг нэмэгдүүлэх зэрэг процессоор дамжуулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн. Сүүн зайрмагтай харьцуулахад энэхүү бүтээгдэхүүний шим тэжээл өндөр бөгөөд калори бага, сайхан амттай.




3

БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 3.1. БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээлийн хөгжил
- 3.2. БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгчид
- 3.3. БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний төрөл зүйл болон үйлдвэрлэлийн өсөлт
- 3.4. Ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг зардал ба үнэ
- 3.5. БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ
- 3.6. БНХАУ-д танигдсан ингэний сүүний брэнд буюу нэрийн бүтээгдэхүүн
- 3.7. Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи
- 3.8. Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж

3.1. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

Сүүлийн 5 жилийн хугацаанд БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ хурдацтай өссөн (Зураг 9-д харуулав). 2021 онд гэхэд, БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийт борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 751.3 сая ам.долларт хүрч, 2016 онтой (556 сая ам.доллар) харьцуулахад даруй 35.1 хувиар өссөн бөгөөд жилийн дундаж өсөлт 5.5 хувьд хүрлээ. Зах зээлийн эрэлтийн өсөлт Европ, Африк, Ази тивийн бусад орнуудтай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна. Цаашид, БНХАУ-ын нэгхүнд ногдох ДНБ 10000 ам.доллар, хүн амын дундаж орлоготой бүлгийнхний тоо 400 саяас давж, дотоодын эрэлт хэрэгцээ өндөр байхаар байгаа нь БНХАУ-ын зах зээлд ингэний сүүн бүтээгдэхүүний зах зээлийн өсөлтийн орон зайг нэмэгдүүлэх болно. Ойрын хэдэн жилд ингэний сүүн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж, дотоодын ингэний түүхий сүү, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийлүүлэлт хомс байх тул импортын орон зай их хэвээр байх төлөвтэй байна.



Зураг 9. БНХАУ-ын сүүн бүтээгдэхүүний зах зээл дээрх борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр), 2016-2021 он

3.2. БНХАУ ДАХЬ ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОМООХОН ҮЙЛДВЭРЛЭГЧИД


Судалгаанаас харахад, БНХАУ-д ингэний сүүний 100 гаруй аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрийн ихэнх нь Зураг 10-т харуулсанчлан, Өвөр Монгол, Шинжианд төвлөрсөн, харин Хэбэй, Ганьсу, Чинхайд цөөн хэдэн аж ахуйн нэгж (Ингэний сүүний томоохон үйлдвэрлэгчдийн танилцуулгыг Хавсралт 1-д үзүүлэв) үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн дотроос ихэнх аж ахуйн нэгжүүд өөрийн гэсэн үйлдвэрлэлийн цех, брэнд бүтээгдэхүүнтэйн зэрэгцээ БНХАУ-ын томоохон хотуудад ингэний сүүний 3000 орчим нэрийн дэлгүүр нээн ажиллуулж байна.



Зураг 10. Ингэний сүүний томоохон үйлдвэрлэгчдийн тархалт

3.3. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ ЗҮЙЛ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨСӨЛТ

Эдүгээ, БНХАУ-д ингэний цэвэр сүү, амталсан буюу амтлаг сүү, ингэний хуурай сүү, ингэний сүүн зайдаг, ингэний эсэг бүтээгдэхүүн, ингэний сүүн шоколад гээд харьцангуй олон төрлийн ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байна. БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний гол нэр төрөл нь ингэний хуурай сүү бөгөөд нийт зах зээлийн 68 хувийг эзэлдэг. Дэлхийн хэмжээнд 2021 оны байдлаар авч үзвэл, ингэний шингэн сүү ингэний сүүн бүтээгдэхүүний нийт зах зээлийн хамгийн өндөр буюу 41 хувийг эзэлж байна.




Зураг 11. Ингэний сүүн бүтээгдэхүүний төрлүүд



Зураг 12. Дэлхийн ингэний сүүн бүтээгдэхүүнд эзлэх хувь

Ингэний сүүгээр хийсэн хүүхдийн тэжээл, ингэний цэвэр хуурай сүү, ингэний цэвэр шингэн сүү, ингэний сүүн шахмал зэрэг нь БНХАУ-д хамгийн их борлуулалттай, эзлэх хувийн жин өндөр бөгөөд тэдгээрийн дотроос хуурай сүү нь хадгалах, тээвэрлэх, хэрэглэхэд дөхөм тул зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлдэг. Ингэний сүүний дэлхийн зах зээлд эзлэх хувьтай харьцуулахад БНХАУ-ын ингэний хуурай сүүний үйлдвэрлэл өсөх орон зай ихтэй хэвээр байна (Зураг 13-т харуулав). Сүүлийн жилүүдэд дотоодын зах зээлд ингэний сүүгээр хийсэн хүүхдийн тэжээлийн үйлдвэрлэл идэвхжиж байгаа хэдий ч борлуулалтын ашиг бага, бүтээгдэхүүний зах зээл болон бусад шалтгааны улмаас хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрлэлийн өсөлт аажмаар удааширч, харин ингэний цэвэр хуурай сүүний үйлдвэрлэл, борлуулалт хурдацтай өссөөр байгаа бөгөөд энэ нь хэрэглэгчид ингэний хуурай сүүг хүлээн зөвшөөрөх хандлага аажмаар нэмэгдэж байгааг харуулж байна.



Зураг 13. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

Санхүүгийн анхдагч бизнесийн мэдээллийн төв болон Тмолл Хүнс компанийн хамтран гаргасан «Насанд хүрэгчдэд зориулсан хуурай сүүний үйлдвэрлэлийн 2021 оны чиг хандлагын тайлан»-д дурдсанаар 2021 онд ингэний хуурай сүүний үйлдвэрлэл хурдацтай буюу даруй 300 гаруй хувиар өсч, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн тэргүүлэгч болсон байна. Цахим худалдааны платформоор дамжуулж хийсэн борлуулалт нийт борлуулалтын 16 хувийг (Зураг 14-т харуулав) эзэлж байна. Эдгээрийн дотроос, ингэний цэвэр хуурай сүү нь тэжээллэг чанар сайтай, зөөвөрлөхөд хялбар, хүн бүр ууж хэрэглэж болохуйц чанартай тул борлуулалтаараа




тэргүүлж байна. Цахим борлуулалт нь дэлгүүрийн борлуулалттай харьцуулахад борлуулалтын үнэ хямд, дэхөм, хурдан бөгөөд борлуулалтын нэгэн гол суваг болж чадсан байна.



Зураг 14. Цахим платформоор дамжуулж хийсэн ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалтын эзлэх хувийн жин

3.4. ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ ЗАРДАЛ БА ҮНЭ

Ингэний саалийн хугацаа богино байх, саахад тавигдах шаардлага өндөр зэрэг нь ингэний сүүний үйлдвэрлэлийн өртөг зардлыг эрс нэмэгдүүлдэг. БНХАУ-д ингэний сүү үнээний сүйтэй харьцуулахад 10 дахин өндөр үнэтэй. Хөдөлмөрийн зардал, тэжээлийн үнэ, уур амьсгалын өөрчлөлт, эрэлт огцом нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр БНХАУ-д ингэний түүхий сүү худалдан авах үнэ сүүлийн жилүүдэд ихээхэн хэлбэлзэлтэй байна. 2014-2021 онд гэхэд, БНХАУ-ын ингэний түүхий сүүний үнэ Зураг 15-д үзүүлсэнчлэн, 25-50 юанийн хооронд хэлбэлзжээ.



Зураг 15. БНХАУ дахь ингэний түүхий сүүний худалдан авах үнийн чиг хандлага

Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын зардал голчлон түүхий эдийн зардал, хөдөлмөрийн зардал, эрчим хүчний зардал, тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал, маркетингийн зардлаас бүрддэг. Тэмээн сүргийн амьдрах орчин өвөрмөц, сүүний гарц хомс, үйлдвэрлэлийн хэмжээ маш бага учраас ингэний түүхий сүү, бэлэн бүтээгдэхүүний үнэ бусад малтай харьцуулахад өндөр байна гэдэг нь илт юм. Ингэний 1 кг түүхий сүү худалдан авах үнэ 2021 онд 25 юань, үүн дээр бусад зардлууд нэмэгдээд бүтээгдэхүүний кг тутмын үнэ 200-300 юань байна. 9 кг ингэний сүүгээр 1 кг ингэний хуурай сүү үйлдвэрлэдэг бөгөөд 1 кг ингэний хуурай сүү үйлдвэрлэхэд ордог түүхий эдийн зардал 225 юань, үүн дээр бусад зардлыг нэмээд ингэний 1 кг хуурай сүүг 1660-3000 юаниар борлуулж байна. Ингэний сүүний үйлдвэрлэлийн өртөг зардал бус нутгаас хамаарч эрс ялгаатай байна. Зорилтот бүлэг, маркетингийн стратеги өөр өөр тул янз бүрийн брэндийн ингэний хуурай сүүний эцсийн үнэ өөр өөр байдаг. Ингэний хуурай сүүний эхний арван брэнд бүтээгдэхүүний 1 кг тутмын дундаж үнэ 1989 юань бөгөөд Казахстаны NC ингэний хуурай сүү нь хамгийн үнэтэй буюу 2860 юань, харин Ханас ингэний хуурай сүүний үнэ 1660 юань байна (Хүснэгт 1-д үзүүлэв).



Зураг 16. Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний зардлын бүтэц


Судалгаагаар тодруулсан, дотоодын томоохон цахим худалдааны платформоор дамжуулан борлуулсан ингэний сүүн бүтээгдэхүүний эзлэх хувийг тоо мэдээллээр үзүүлсэн болно. Ингэний сүүн шахмалын үнэ арваас хэдэн зуу гаруй юань, нэг шил нь хэдэн арван юань, ингэний шингэн сүү хэдэн зуун юань, дундаж үнэ нь 500 орчим юань байна. Ингэний сүүгээр хийсэн хүүхдийн сүүн тэжээлийн хувьд, бусад орц найрлага нэмдэг тул агууламж, ангиллаасаа хамаарч, үнэ нь хэдэн арваас хэдэн зуун юань хүртэл хэлбэлзэг бөгөөд үйлдвэрлэн борлуулж буй янз бүрийн ингэний сүүн бүтээгдэхүүний үнэ өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна.

Ерөнхийдөө бол, их дэлгүүр буюу супермаркетаар борлуулж буй ингэний сүүний хэмжээ цахимаар борлуулж буйгаас арай илүү бөгөөд цахим борлуулалт нь олон суваг болон зардлыг бууруулдаг бол супермаркетууд олон тооны борлуулалтын суваг, дэлгүүрүүдээр дамжуулж борлуулалт хийдэг тул Зураг 17-д үзүүлсэнчлэн, борлуулалтын үнэтүүнийг дагаадаяндаа өсдөг. Цахим худалдаа эрчимтэй хөгжихийн хэрээр хүмүүс хялбар, түргэн худалдан авалт хийхийг илүүд үздэг болсон бөгөөд ингэний сүүн бүтээгдэхүүний цахим худалдааны үнэ ч хямд байна. Өөр өөр брэнд, үйлдвэрлэгч, үйлдвэрлэлийн бус, борлуулалтын суваг зэргээс шалтгаалан ингэний сүүн бүтээгдэхүүний үнэ жигд бус, нэг ижил ангиллын ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн борлуулалтын үнэ өөр өөр, цахим худалдааны болон дэлгүүрийн үнэ ч мөн маш өөр байдаг.



Хүснэгт 1. Ингэний цэвэр хуурай сүүний гол гол брэнд бүтээгдэхүүний жижиглэнгийн үнэ

Тоо	Нэр	Үнэ (Юань/кан)	Цэвэр жин (кг/кан)	Үнэ (юань/кг)
1	Дубайн камеликус (Dubai Camelicious)	1036	0.40	2590
2	Алтан тэмээ (Golden Camel)	599	0.30	1997
3	Казахстан Эн Си (Kazakhstan NC)	429	0.15	2860
4	Жинхэнэ алт (Original gold)	398	0.33	1206
5	Цөлийн бурхан (God of the desert)	628	0.38	1710
6	Аяндаа цувьсан (That wiredrawing)	798	0.30	2660
7	Ван юань (Wang yuan)	588	0.32	1838
8	Цянжуэ (Qianjue)	489	0.30	1630
9	Ханас (Hanas)	498	0.30	1660
10	Хан Му Тан (Han Mu Tang)	508	0.30	1693
	Дундаж			1984.4



Зураг 17. Янз бүрийн сувгаар борлуулсан ингэний сүүн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл

3.5. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУЛЖЭЭ

3.5.1. Тэмээний гол үүлдүүд

Судалгааны тайланд дурдсанаар, БНХАУ-ын тэмээн сүргийн тоо толгой, тэмээ судлал, технологийн салбарын хөгжлийг сурталчлан таниулж буй онцлог арга зам, үндэсний бодлогыг хэрэгжүүлэхэд үзүүлж буй дэмжлэг, сүүний аж ахуй эрхлэх бааз суурийг бий болгох, мэргэжлийн хоршод болон сүүний аж ахуйн бүтээн байгуулалтыг үзүүлэн таниулах бааз суурь зэрэгт өөрчлөлт орж байна. Түүнчлэн, тэмээний аж ахуйг хөгжүүлэхийн зэрэгцээ, бид ингэний сүүний үйлдвэрлэлийн эрүүл, тогтвортой хөгжлийг хангахын тулд экологийн орчныг хамгаалах, хос бөхт тэмээний экологийн бэлчээр, нөөцийг ихээр бий болгох, тэмээн соёл шингэсэн үйлдвэрлэлийг идэвхтэй хөгжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна.



Зураг 18. Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээ

3.5.2. Ингэний сүүн бүтээгдэхүүний жижиглэн худалдааны сувгууд


Ингэний сүүн бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд 3000 гаруй нэрийн дэлгүүр, жижиглэн худалдааны дэлгүүрээр борлуулсан хэвээр байна. Гэсэн хэдий ч, ингэний сүүн бүтээгдэхүүний цахим худалдааны платформын борлуулалтын хэтийн төлөв өөдрөг гэж үзэж болохоор байна. Жижиглэнгийн цахим худалдаа нь уламжлалт жижиглэнгийн худалдааны цаг хугацаа, орон зай, тэр ч бүү хэл үндэсний хил хязгаарыг давж, завсрын зуучлал болон үйл ажиллагааны буюу тээврийн зардлыг бууруулж, улам олон хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрөгдөж байна. Ингэний сүүн бүтээгдэхүүн нь нэмүү өртөг өндөр, тодорхой хэрэглэгчдийн бүлэгтэй, хэрэглэгчид тархай бутархай оршин суудаг тул цахим худалдааны платформ нь уламжлалт жижиглэнгийн худалдааны сувагтай харьцуулахад өрсөлдөх чадвар өндөр. БНХАУ-ын цахим худалдааны платформуудын сүүлийн таван жилийн мэдээллээс харахад, ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын жилийн дундаж өсөлт 6.9 хувь байгаа бөгөөд цаашид өсөх хандлагатай байна (Зураг 19-д үзүүлэв).



Зураг 19. БНХАУ-ын цахим худалдааны платформоор хийгдсэн ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт



БНХАУ-д ингэний сүүн бүтээгдэхүүний цахим худалдаа голчлон Taobao, JD.COM, Tik Tok болон Quick hand гэсэн дөрвөн том платформ дээр хийгддэг бөгөөд эдгээрээс Таобао хамгийн өндөр борлуулалттай буюу уг зах зээлийн 64 хувийг эзэлж байна (Зураг 20-т үзүүлэв). Мэдээллийн технологи, дэд бүтцийг хөгжүүлж, компьютер, гар утас зэрэг орчин үеийн харилцаа холбооны хэрэгслүүдийг түгээн дэлгэрүүлснээр дэлхийн ихэнх улс орнуудын жижиглэнгийн цахим худалдааны платформуудын зах зээлд эзлэх хувь улам өргөжин хөгжих болно.



Зураг 20. Ингэний сүүн бүтээгдэхүүн борлуулж буй дотоодын томоохон цахим худалдааны платформуудын эзлэх хувийн жин

3.6. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЛОНД ТАНИГДСАН БРЭНДҮҮД

Эдүгээ, БНХАУ-д ингэний сүүний төрөл бүрийн брэндүүд бий. Nalasichun, Wangyuan, Zhongtuo, Desert platinum, Yibate, The god of desert , Raw gold, Wangpaituo, Meidun, Silutuobao, Yuanxiyu, Oupushan, Gaoquan, Tuoneng, Tuomuer, Youaibeite, Paliyaduo, Xiyuzijia болон бусад брэндүүд. Эдгээрийн дотроос, Wangyuan, Desert platinum, Zhongtuo, God of the Desert and Raw gold брэндүүдийн хувьд, ингэний сүүний судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг нэгэн зэрэг хийгддэг онцлогтой. Бүтээгдэхүүний баялаг төрөл зүйл, үйлдвэрлэлийн иж бүрэн сүлжээ, улс даяарх борлуулалт, үйлчилгээний сүлжээг бий болгосноор БНХАУ-ын бүтээгдэхүүнүүд улсынхаа ингэний сүүний хамгийн өндөр үнэтэй буюу дээд зэрэглэлийн зах зээлийг эзлээд байна.

Импортын ингэний сүүн бүтээгдэхүүнд GOLDEN CAMEL, Camelicious, Camelait, NutritionCare Nuxinbao зэрэг бүтээгдэхүүнүүд багтдаг ба GOLDEN CAMEL нь импортын ингэний сүүний салбарт тэргүүлэгч брэндэд тооцогддог. Энэ нь Казахстанд Хэйлунжан Дачин Голден Камел ХХК (Heilongjiang Daqing Goldencamel Co., LTD)-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан, Казакстаны БНХАУ-ын зах зээл дахь сүүн бүтээгдэхүүний анхны төлөөлөгчдийн нэг юм. Camelicious брэнд нь өндөр чанарын цэвэр сүү гэдгээрээ дэлхийд алдартай ингэний сүүний брэнд юм. Уг брэнд нь АНУ-ын Хүнс, эмийн чанарын хяналтын газар болон Европын холбооны чанарын баталгаажуулалтын шаардлагыг хангасан бөгөөд Camelicious нь ингэний шингэн

болон хуурай сүүний судалгаа, хөгжүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Camelicious нь олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цогц сүлжээг бий болгосон. Гадаадын алдартай брэндүүдийн ихэнх нь тэмээн сүрэгт зориулсан өөрийн гэсэн онцгой бэлчээртэй, менежментийн хатуу горим журам баримталдаг. Тэдгээр нь ингэ сах автомат төхөөрөмж, хуурай сүү боловсруулах иж бүрэн тоног төхөөрөмжтэй төдийгүй, мөн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг аль болох хангахын тулд чанарын болон үйл ажиллагааны стандартыг хатуу чанд баримталж бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг. Ингэний сүүн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулгыг Хавсралт 2-т үзүүлэв.

3.7. ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ


Ингэний сүүг хэрэглэгч, зах зээл сайшаан хүлээж авч буй тул чанар нь түүний хөгжлийн гол түлхүүр юм. Өнөөгийн өсөлтийн хувьд, ингэний сүүний зах зээл аажмаар өргөжиж байгаа ч, голдуу баруун бус нутагт тэмээ үржүүлдэг тул улс даяарх хэрэгцээг хангахад тээврийн зардал өндөр байна. Иймд, ингэний сүүн бүтээгдэхүүнийг ихэвчлэн хуурай сүү хэлбэрээр үйлдвэрлэж байна. Шингэн сүүг ариутгаж, модуляц хийсний дараа хуурай сүү үйлдвэрлэхэд гол төлөв хөлдөөх, хатаах технологийг ашигладаг бөгөөд энэ нь түүхий эдийн амт, тэжээллэг чанарыг илүү сайн хадгалахын сацуу хадгалах хугацааг уртасгадаг. Ингэж үйлдвэрлэсэн ингэний сүү нь хүссэн үедээ уухад тохиромжтой байдаг. Түүхий сүүг ангилан ялгаж, ариутгахаас эхлээд жигдрүүлэх, өтгөрүүлэх гээд үйлдвэрлэлийн процесс үргэлжилдэг тул процесс бүр өөрт нь дүйцсэн техникийн мөн чанаруудтай байдаг.

3.7.1. Шингэн сүү үйлдвэрлэлийн процесс

Шингэн сүү нь чанарын шаардлага хангасан түүхий сүүг тодорхой температурт халааж ариутгасны дараа жижиглэн савлаж худалдаалдаг ундны сүү юм. Олон улсын сүүний холбоо (IDF)-ны тодорхойлсноор, шингэн сүү гэдэг нь халааж боловсруулсан буюу цэвэршүүлсэн сүү, ариутгасан сүү болон тараг гэсэн гурван төрлийн цагаан идээний ерөнхий нэр томьёо юм.

Шингэн сүүг дараах ерөнхий процесс буюу шат дамжин үйлдвэрлэдэг:

Түүхий сүү хүлээж авах → цэвэр сүү → хөргөх → стандартчилал → урьдчилан халаах → жигдрүүлэх → хэт өндөр температурт шуурхай ариутгах (эсвэл ариутгах) → хөргөх → асептик савлагaa → бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах



Зураг 21. Шингэн сүү үйлдвэрлэлийн дарааллыг харуулсан график дүрслэл




Зураг 22. Шингэн сүү үйлдвэрлэлийн шугамын зураг

3.7.2. Хуурай сүү үйлдвэрлэлийн процесс

Хуурай сүүний төрөлд хольцгүй хуурай сүү, тостой хуурай сүү, өндөр тостой хуурай сүү, чихэрлэг хуурай сүү, модуляц хийгдсэн хуурай сүү, хуурай буюу хатаасан тараг ордог. Хуурай сүү үйлдвэрлэх аргыг хөлдөөх арга, шүрших арга гэж хоёр хуваадаг. Хөлдөөх аргыг төвөөс зугтах зарчмаар хөлдөөх арга ба хөлдөөж хатаах арга гэж хувааж болно. Хөлдөөх арга нь бага хэмд ашигладаг арга тул сүүнд агуулагдах бүх шим тэжээлийг хадгалж, халаалтын улмаас бүтээгдэхүүний өнгө, амтанд өөрчлөлт орохоос зайлсхийх боломж олгодог. Гэхдээ, энэ арга нь өндөр өртөгтэй тул өргөн сурталчлан таниулах боломжгүй байдаг.

Нойтноор тоосруулан шүрших аргаар үйлдвэрлэсэн хуурай сүү нь бүтээгдэхүүний чанар сайтай, уусах чанар өндөртэй, тасралтгүй автоматаар үйлдвэрлэхэд тохиромжтой байдаг тул БНХАУ-д нойтон шүрших арга, хуурай-нойтноор холих аргыг ихэвчлэн ашигладаг. Хэд хэдэн гол нэрийн хуурай сүүг үйлдвэрлэхэд дараах үйлдвэрлэлийн процессыг ашигладаг:

Түүхий сүүг хүлээж авах → цэвэр сүү → ариутгах → хүйтэнд хадгалах → найрлага тохируулах (хоол тэжээлийн баяжуулагч болон бусад дагалдах туслах нэмэлтийг нэмэх) → жигдрүүлэх → хүйтэнд хадгалах → ариутгах ба өтгөрүүлэх → тоосруулан хатаах → шигших, хатаах (эсвэл шингэрүүлсэн давхарга үүсгэх) → савлах



Зураг 23. Хуурай сүү үйлдвэрлэлийн дарааллыг харуулсан график дүрслэл



Зураг 24. Хуурай сүү үйлдвэрлэлийн шугамын зураг

3.7.3. Мембран технологи

Мембран технологи нь байгаль орчны бохирдол багатай, эрчим хүч бага зарцуулдаг, нэмэлт бодис хэрэглэх шаардлагагүй, бүтээгдэхүүнийг дулааны гэмтлээс зайлсхийх, шүүж цэвэрлэх явцад бодисыг ялгах, өтгөрүүлэх боломжтой зэрэг давуу талтай тул сүүн бүтээгдэхүүн боловсруулахад илүү практик ач холбогдолтой, цаашид өргөнөөр хэрэглэх боломжтой гэж үздэг.

Одоогийн байдлаар сүүн бүтээгдэхүүн боловсруулахад дараах мембран технологийг голчлон ашиглаж байна. Үүнд: (1) өтгөрүүлсэн шарсүүний урвуудиализийн технологи; (2) Шар сүүг давсгүйжүүлэх, өтгөрүүлэх, циклийн боловсруулалтын ус, циклийн шүлтлэг болон хүчил цэвэрлэх уусмал, чихрийн уусмал, уургийн гидролизат, эсгэх уусмалыг өтгөрүүлэх, цэвэршүүлэхэд нано шүүлтүүрийн технологийг ашиглах; (3) Уургийн баяжуулалтхийх, ялгах, цэвэршүүлэхэдхэтнарийн шүүлтүүрийн технологийг ашиглах; (4) Бичил биетэн, бактери, вирус, эсрэг биетийг устгахад бичил биетний шүүлтүүрийн технологийг ашиглах; (5) Цэнэглэгдсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг (биологийн идэвхт уураг, пептид болон ижил төстэй молекул жинтэй боловч өөр өөр цахилгаан цэнэгтэй бусад жижиг молекул жинтэй бүрэлдэхүүн хэсгүүд гэх мэт) сонгон ялгах, цэвэршүүлэх, гидролизат боловсруулах, лактоферриныг сэргээхэд цахилгаан мембран шүүлтүүрийг ашиглах гэх мэт.

3.7.4. Биотехнологи

Биотехнологи нь гений инженерчлэл, эсийн инженерчлэл, ферментийн инженерчлэл, эсгэлтийн инженерчлэл, биохимиин инженерчлэл зэрэг орчин үеийн шинэ технологийн дэвшлийн нэгэн чухал хэсэг нь юм. Сүүлийн жилүүдэд, бичил биетний омгийг хувиргахад гений инженерийн технологийг ашиглах, тусгай ферментийн системийг үйлдвэрлэхэд инженерчлэлийн бактерийг ашиглах, баяжуулсан сүү үйлдвэрлэх биотехнологийг сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглаж байна.

3.7.5. Хүйтэн аргаар ариутгах технологи

Хүйтэн аргаар ариутгах технологи нь сүүлийн жилүүдэд илүүтэй судлагдаж буй ариутгах технологийн нэг төрөл юм. Ариутгах явцад бүтээгдэхүүний температур нэмэгдэхгүй, эсвэл маш бага нэмэгддэг тул хүнсний найрлага дахь функциональ бүрэлдэхүүн хэсгүүдийн физиологийн идэвхийг хадгалахаас гадна өнгө, үнэр, амт, тэжээллэг чанарыг хадгалахад тустай байдаг.

Одоогийн байдлаар, өндөр даралтын боловсруулалтын технологи, өндөр даралтын импульсийн цахилгаан талбайн ариутгал, хэт авиаагаар ариутгах, нянгийн эсрэг ферментээр ариутгах, бичил долгиноор ариутгах, соронзон долгиноор ариутгах, индукцийн электроноор ариутгах, цацраг ашиглан ариутгах, импульсийн хүчтэй гэрлээрариутгах, хэтягаантuya, озонаорариутгах технологиудыг сүүний үйлдвэрлэлд ашиглах чиглэлээр янз бүрийн түвшинд судалгаа хийгдэж, мөн ашиглагдаж байна.

Эдүгээ, дулаанаар ариутгах, халааж боловсруулах, хэт өндөр температурт ариутгах технологийг БНХАУ-ЫН СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛД голчлон ашиглаж байна.

3.7.6. Илрүүлэгч технологи

Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжихийн хэрээр сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд илрүүлэгч, тэр дундаа сүүнд агуулагдах идэвхтэй бодис, бага



агууламжтай боловч сүүнд ихээхэн нөлөө үзүүлдэг хорт бодисыг илрүүлэхэд үр дүнтэй илрүүлэгч технологи шаардагдах болсон. Гадаадын улс орнуудад хэт авианы технологи, биосенсор, иммунологийн технологи, өндөр хүчин чадалтай капилляр электрофорезийн шинжилгээний технологийг илрүүлэгчээр, шуурхай илрүүлэгчээр ашигладаг.

3.7.7. Реологийн шинж чанарыг тодорхойлох шинжилгээний арга техник

Реологийн шинж чанарыг тодорхойлох шинжилгээний технологийг сүүн бүтээгдэхүүний шинжлэх ухааны судалгааны чухал арга, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн техникийн түвшин дээшлүүлэх гол арга гэж үздэг бөгөөд энэ нь инженер техникийн ажилтнуудад бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн холбоос бүрийн нөлөөллийг ойлгох, хянах боломжийг олгодог.

3.7.8. Хөлдөөж хатаах технологи

Хөлдөөж хатаах технологи нь халуунд мэдрэмтгий бодисуудын исэлдэж, муудахаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх бүтээгдэхүүний гадаргуу хатуурахаас сэргийлж, шингэн сэлбэлтийг сайжруулж, хүнсний анхны чанарыг дээд зэргээр хадгалах боломж олгодог. Баяжуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг ийм аргаар голчлон боловсруулдаг. БНХАУ-д үүнийг анхдагч өсгөвөрийг хөлдөөж хатаахад голчлон ашигладаг бөгөөд эдүгээ зарим баяжуулсан сүүг хөлдөөж хатаах технологиор үйлдвэрлэж байна.

3.8. ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Эдүгээ, сүүний үйлдвэрүүд хуурай сүүнээс гадна эсгэсэн сүү, халааж ариутгасан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг судалж байна. Сүүлийн жилүүдэд, бага хэмжээгээр үйлдвэрлэдэг сүүг түгээмэл буюу олонд танигdsan сүү үйлдвэрлэдэгтэй ижил аргаар халааж боловсруулах туршилт хийж эхлээд байна. Сүү хадгалах танк, шүүлтүүр, жигдруүлэгч, ариутгах сав, хөргөлтийн сав болон хэд хэдэн тоног төхөөрөмжийн тусlamжтайгаар түүхий сүүг ариутгах, бохирдлыг арилгах, бусад боловсруулалт хийх боломжтой. Хэрэв та тараг бүрэхээр бол, сүүг хөргөсний дараа цэвэр өсгөврийн хөрөнгө ашиглан бүрж болно. Хэрэв та шинэхэн сүү үйлдвэрлэхийг хүсвэл, сүүг тодорхой температурт хөргөсний дараа шууд савлана. Орчин үеийн технологи, тоног төхөөрөмж ашиглан бага хэмжээгээр үйлдвэрлэдэг сүүг илүү олон арга хэлбэрээр зах зээлд танилцуулж байгаа нь сүүний үйлдвэрүүдэд зах зээлд гарах боломж олгоод зогсохгүй, хэрэглэгчдэд бэлэг барьж буй хэрэг гэж ойлгож болно.

3.8.1. Сүү, сүүн бүтээгдэхүүн баяжуулах тоног төхөөрөмж

БНХАУ-д хуурай сүүний үйлдвэрлэлд дан нөлөө бүхий болон давхар нөлөөтэй ууршуулагчийг ашигладаг. Хэд хэдэн томоохон сүүний үйлдвэрүүд шингэн сүү үйлдвэрлэхдээ дэвшилтэт флаш ууршуулалтыг ашиглаж байна.

3.8.2. Жигдруүлэгч

Жигдруүлэгч нь сүүн бүтээгдэхүүн дэх тосны бөмбөлгийг жижиглэж, сүүн бүтээгдэхүүний чанарыг сайжруулахаас гадна сүүн бүтээгдэхүүний хадгалах хугацааг уртасгах боломж олгодог.

3.8.3. Үйлдвэрлэлийн асептик шугам

БНХАУ-д сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ өндөр температурт богино хугацаанд ариутгах, хэт өндөр температурт шуурхай ариутгах арга, тоног төхөөрөмжийг өргөн ашигладаг боловч энэ нь үндсэндээ үйлдвэрлэлийн шугамыг нэвтрүүлж буй хэрэг юм.

3.8.4. Илрүүлэгч тоног төхөөрөмж

Сүүн бүтээгдэхүүнд түүхий сүүний чанарыг шалгах, тест буюу сорилт хийх автомат төхөөрөмж, сүүн бүтээгдэхүүнийг шуурхай шалгах тусгай төхөөрөмж ашигладаг. Гэвч ихэнх компаниуд уламжлалт, сонгодог тест хийх аргыг хэрэглэсээр байна.

3.8.5. Хуурай сүү үйлдвэрлэх тоног төхөөрөмж

БНХАУ-д хоёр шатлалтай хатаах төхөөрөмж, тоосруулах хатаах төхөөрөмж зэрэг хуурай сүү үйлдвэрлэдэг дотоодын олон тоног төхөөрөмж бий.

3.8.6. Жижиг бяслаг боловсруулах төхөөрөмж

Бяслагийн үйлдвэрлэл нь ирээдүйд БНХАУ-ын хөгжүүлэх сүүн бүтээгдэхүүний гол чиглэлийн нэг юм. БНХАУ-ын бяслагийн үйлдвэрлэл маш бага учраас гадаад орнуудын техники, технологийг голчлон нэвтрүүлдэг.

3.8.7. Сүүн шахмал боловсруулах тоног төхөөрөмж

Шахмал шахагчийг ашиглан автомат эргэлт хийх, шахмалыг тасралтгүй шахах замаар түүхий эдийг шахаж, дугуй, сийлмэл, тодорхой хэлбэр дүрстэй ингэний сүүн шахмал болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг.

3.8.8. Ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ба гол параметрүүд.

Хүснэгт 2. Ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ба гол параметрүүд

#	Төхөөрөмжийн нэр	Үндсэн буюу гол шаардлага	Наад захын параметрүүд эсвэл тусгай шаардлага
1	Сүү хадгалах тоног төхөөрөмж	Үйлдвэрт шаардлагатай түүхий сүүг сүү хадгалах танканд 0-4 хэмд хадгална.	Тогтмол хэмийн автомат систем буюу дулаан хадгалах системтэй байх. Үйлдвэр нь 30 тонноос дээш сүү хадгалах хүчин чадалтай байх ёстой.
2	Сүү цэвэршүүлэх тоног төхөөрөмж	Сүү цэвэрлэгч сеператор	5000 кг/цаг-ийн хүчин чадалтай байх 2-оос дээш багц
3	Жигдруүлэгч	Өндөр даралтын хоёр-үе шаттай жигдруүлэгч	5000 кг/цаг-ийн боловсруулах хүчин чадалтай байх 2-оос дээш багц
4	Хөргөлтийн тоног төхөөрөмж	Аммиак эсвэл фторын хөргөлтийн төхөөрөмж эсвэл бусад түүнтэй адилтгах төхөөрөмж	Ажлын хэвийн нөхцөлд, хөргөлтийн 54 кВт-аас дээш хүчин чадалтай тоног төхөөрөмж.
5	Багцлах тоног төхөөрөмж	Багцлах, хэмжих зориулалттай электрон жин, өндөр хурдтай хэрчих болон бусад туслах тоног төхөөрөмж	Олноор хэмжигчийг багцлах хэмжилт хийхэд, өндөр хурдны хэрчигчийг савгүйгээр шуурхай хэрчилт хийхэд ашиглана.



6	Баяжуулах тоног төхөөрөмж	Давхар эсвэл олон талт үйлчилгээтэй вакум өтгөрүүлэн ууршуулагч	Нэг машины ууршуулах хүчин чадал нь 2400 кг/цагаас их байх.
7	Ариутгах тоног төхөөрөмж	Ялтаст буюу хоолойн төрлийн эсвэл бусад ижил төстэй ариутгах төхөөрөмж	Ариутгах төхөөрөмжийн дулааны нөхөн сэргэлтийн түвшин 90 хувиас дээш байх.
8	Өндөр даралтын насос	/	500 кг/цагаас дээш хүчин чадалтай байх.
9	Тоосруулан хатаах тоног төхөөрөмж	Тоосруулан хатаах босоо тоног төхөөрөмж	Нэг цамхгийн ус ууршуулах хүчин чадал 500 кг/цагаас илүү байх.
10	Агаар цэвэршүүлэх систем	/	300000-аас дээш түвшний агаар цэвэршүүлэх систем (тоосны зөвшөөрөгдөх хэмжээ шаардагдахгүй).
11	Савлах тоног төхөөрөмж	Бүрэн автомат савлах тоног төхөөрөмж	Автомат жин хэмжигч, автомат залруулах систем бүхий битүү эсвэл хагас хаалттай бүрэн автомат савлах машин.
12	Цэвэрлэгээний тоног төхөөрөмж	Задаргаагүү цэвэрлэгээ хийх (CIP) автомат цэвэрлэгээний төхөөрөмж	Үйлдвэрлэлийн бүх шугамд харагдахгүй, хамгаалах боломжгүй өнцөг буюу орон зай байхгүй байх.
13	Түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүн хэмжих тоног төхөөрөмж	Хэмжил зүйн баталгаажуулалтын шаардлага хангасан төхөөрөмж	Жин хэмжилт нь батлагдсан
14	Урьдчилан холих тоног төхөөрөмж	Хэмжил зүйн баталгаажуулалтын шаардлага хангасан төхөөрөмж	Урьдчилан холих тоног төхөөрөмж нь хагас хаалттай байна.
15	Холигч тоног төхөөрөмж	Автомат болон автомат бус хэмжин холигч	Холигч тоног төхөөрөмж нь хаалттай, тасралтгүй ажиллагаа бүхий, 500 кг/цагаас дээш боловсруулах хүчин чадалтай байх
16	Хонгил ариутгах тоног төхөөрөмж	Хэт ягаан туяагаар ариутгах эсвэл ариутгалын бусад байгууламж	Хонгил ариутгах тоног төхөөрөмж нь тасралтгүй, хаалттай ажиллагаатай, ариутгал хийсний дараа агаарын орчин цэвэршдэг байх.
17	Савлах тоног төхөөрөмж	Бүрэн автомат савлах машин	Автомат жин хэмжигч, автомат залруулах систем бүхий битүү эсвэл хагас хаалттай бүрэн автомат савлах машин.
18	Агаар цэвэршүүлэх тоног төхөөрөмж	/	300000-аас дээш түвшний агаар цэвэршүүлэх систем (тоосны зөвшөөрөгдөх хэмжээ шаардагдахгүй).

4

БНХАУ ДАХЬ ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

- 4.1. БНХАУ-ын сүүн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаа
- 4.2. Амт шимтийн сонголт буюу хүсэл сонирхол
- 4.3. Бүтээгдэхүүний хэрэглээ



БНХАУ-ын сүүн бүтээгдэхүүний хэрэглээхурдацтай нэмэгдэж буй хэдийч хэрэглээний түвшин өндөр биш хэвээр байна. Хэрэглээний бүтэц илт өөрчлөгдөж байгаа ч, нэмүү өртөг өндөртэй сүүн бүтээгдэхүүний хэрэглээ бага байна. Хэдийгээр, хот, хөдөөгийн хэрэглээний ялгаа байсаар байгаа ч аажмаар багасаж байна. Хэрэглээ нь орлогын түвшинтэй нягт холбоотой бөгөөд бус нутгийн гэсэн онцлогтой байдаг. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээнд хувь хүний хүчин зүйл, хүрээлэн буй орчны хүчин зүйл, бүтээгдэхүүний хүчин зүйл зэрэг гурван хүчин зүйл голчлон нөлөөлж байгааг Зураг 25-д үзүүллээ. Ингэний сүүг цахимаар худалдан авагчдын дунд чамин тансаг, үнэ бүхий зүйлийн хэрэглээтэй ээжүүд, дунд насныхан болон өндөр настнууд голчилж байна. Олон тооны цахим худалдааны мэдээллийн тайлангаас харахад, далайн эрэг орчмын бус нутгууд болон шинэ нэгдүгээр зэрэглэлийн хотууд дахь хүн амын бүлгүүд ингэний сүүний цахим худалдааны гол хэрэглэгчид бөгөөд хэрэглээний хэмжээ, эзлэх хувь бусад нэгдүгээр зэрэглэлийн хотуудынхаас хамаагүй өндөр байна. Үүний дотор Шанхай, Гуанжоу, Сычуань, Зүүн хойд Хятад болон бусад бус нутгууд хэрэглээний жагсаалтыг тэргүүлж байна. Хүйсийн харьцаагаар үзвэл, эмэгтэйчүүдийн худалдан авах эрэлт 70 орчим хувийг эзэлж байгаа бол, насаар ангилж үзэхэд, ингэний сүү худалдан авч буй хэрэглэгчдийн насны зөрүү бага байна. Жижиг хотуудын чамин тансаг, үнэ бүхий зүйлийн хэрэглээтэй ээжүүд, ахимаг насны дундаж давхаргынхан болон өндөр настнуудын дунд ингэний сүүний эрэлт болон худалдан авалт ихээхэн нэмэгдсэн бөгөөд тэдний хэрэглээний түвшин бусад бүлгүүдтэй харьцуулахад 2 дахин илүү байна. Тэд одоо болон ойрын ирээдүйд ингэний сүүний «гол хэрэглэгчид» болох хандлагатай байна. Үнэлгээ, санал хүсэлт, асуулга болон бусад мэдээллийн судалгааны үр дүнгээс харахад, хэрэглэгчид ингэний сүүн бүтээгдэхүүн худалдан аваадаа тэжээлэг чанар, сүүний гарал үүсэл, бүтээгдэхүүний шинж чанар, амт, үйлдвэрлэлийн баталгаа, аж ахуйн нэгжийн хүчин чадалд илүү анхаардаг болох нь тогтоогдсон. Хэрэглэгчдийн 90 гаруй хувь нь ингэний сүүний талаарх мэдлэгийг урьдчилан олж авах, шим тэжээлтэй холбоотой тоо мэдээлэлд хамгийн ихээр анхаарал хандуулах, илүү мэргэжлийн, илүү их эрүүл мэндийн шаардлага тавихаар байна.



Зураг 25. Хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлдөг хүчин зүйлс

4.1. БНХАУ ДАХЬ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

Хөдөөгийн хэрэглэгчдийн сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд итгэх хотын хэрэглэгчдийнхээс арай доогуур байгаа нь хөдөөгийн хэрэглэгчид сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын тухай мэдээлэл авахад хүндрэлтэй, «сүүн бүтээгдэхүүний талаарх цуурхал»-д өртөмтгий байдагтай холбоотой байж болох юм. Хэрэглэгчид хэрэглээ багатай эсэх нь тэдний итгэлийн түвшин тодорхойлох гол хүчин зүйл юм. Хэрэглээний туршлага багатай хэрэглэгчдийн сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт итгэх итгэл хэрэглээний тааруу туршлагагүй хэрэглэгчдийнхээс 1.2 пунктээр доогуур байна. Боловсролын түвшин мөн нэгэн чухал хүчин зүйл юм. Өндөр боловсролтой, өндөр орлоготой хэрэглэгчдийн сүүн бүтээгдэхүүнд итгэх итгэл доогуур байдаг. Гэхдээ сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар хангалттай мэдээлэл авч чадвал дүн шинжилгээ, дүгнэлт хийсний дараа сүүний үйлдвэрлэлд итгэх итгэл нь нэмэгдэнэ. Хэрэглэгчдийн хамгийн их анхаарал татдаг дотоодын хүүхдийн хуурай сүүн тэжээлд итгэх итгэл сүл хэвээр байна. Хүүхдийн хуурай сүүн тэжээлийг худалдан авч буй хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүн нь чанарын гэрчилгээтэй эсэх, өөрөөр хэлбэл чанарын хувьд аюулгүй эсэх, дараа нь органик эсэх, мөшгөх боломжтой эсэхэд хамгийн их санаа зовдог. Хэрэглэгчид өндөр үнээр худалдан авах хүсэл эрмэлзэлтэй байгаа нь мэдээллийн тэгш бус байдлын асуудал оршин буйг харуулж байна. Хэрэглэгчид хүүхдийн хуурай сүүн тэжээлийн үйлдвэрлэлийн процесс, бүтээгдэхүүний чанар болон бусад холбогдох мэдээллийг ойлгохгүй, зөвхөн үнээр нь сайн эсэхийг дүгнэх боломжтой байдаг. Шингэн сүүний хэрэглээ жигд бус тархалттай бөгөөд үнэ нь хэрэглээнд нөлөөлдөг гол хүчин зүйл юм. Нэг өрх жилд дунджаар наад зах нь 78 литр шингэн сүү хэрэглэдэг. Нэг өрх дөрвөн гишүүнтэй гэж тооцвол нэг хүнд ногдох шингэн сүүний хэрэглээ 19.5 литр байгаа нь дэлхийн нэг хүнд ногдох сүүн бүтээгдэхүүний хэрэглээнээс хол хоцорсныг харуулж байна. Үнэ болон боловсролын түвшин нь шингэн сүүний хэрэглээнд нөлөөлдөг гол хүчин зүйл юм. Үнийн 1 хувийн өсөлт тутамд хэрэглэгч өрхийн сарын дундаж хэрэглээ 0.6 хувиар, боловсролын түвшин өндөр байх тусам хүмүүс сүүн бүтээгдэхүүний шим тэжээл, үйлчилгээг ойлгож, хэрэглээ нь нэмэгддэг. Сүүний үйлдвэрлэлд гол үүрэгтэй оролцдог таван байгууллагад (сүүний фермерүүд, сүүний үйлдвэрүүд, жижиглэн худалдаа эрхлэгчид, төрийн болон гуравдагч этгээдийн туршилт, шинжилгээний байгууллагууд) хэрэглэгчдийн итгэх итгэлийн түвшин судлахад, хэрэглэгчдийн төрд итгэх итгэл хамгийн өндөр, харин жижиглэн худалдаа эрхлэгчдэд хамгийн бага итгэдэг болох нь тогтоогдсон.

Бүтээгдэхүүний брэнд нь хэрэглэгчдийн зан төлөвт ихээхэн нөлөөлдөг. Хэрэглэгчид ингэний сүүний брэндийн талаар маш өндөр мэдлэгтэй байдаг бөгөөд энэ талаарх мэдлэг ойлголт нь тухайн брэндийг хүлээн зөвшөөрсөн байдалтай нь буюу танигdsan байдалтай нь эерэг хамааралтай байдаг. Ингэний сүүн бүтээгдэхүүний төлөв чанар буюу өвөрмөц шинж чанар нь хэрэглэгчдийн худалдан авалт хийх зан төлөвт нөлөөлдөг. Ингэний сүүн бүтээгдэхүүний шинж чанар, нэрлэвэл, амт, аюулгүй байдал, эрүүл мэнд, савлагаа, техникийн үзүүлэлт дотроос хэрэглэгчдийн сонголтод нөлөөлдөг хүчин зүйлүүд эхний хоёроос бусад нь бага хувийг эзэлдэг ажээ.



4.2. АМТ ШИМТИЙН СОНГОЛТ БЮУХ ХҮСЭЛ СОНИРХОЛ

Эдүгээ, БНХАУ-д ингэний цэвэр сүү, амталсан буюу амтлаг сүү, ингэний хуурай сүү, ингэний сүүн зайрмаг, ингэний эсэг бүтээгдэхүүн, ингэний сүүн шоколад гээд харьцангуй олон нэр төрлийн ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байна. БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүнд хуурай сүү давамгайлдаг ба мөн сүүн шахмал, бага хэмжээний шингэн сүү үйлдвэрлэн борлуулж байна.

2020 оны дэлхийн хэмжээний нийт ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалтын 40.9 хувийг ингэний шингэн сүү, 20.7 хувийг ингэний хуурай сүү, 13.9 хувийг амтлаг сүү, 11.7 хувийг ингэний сүүн зайрмаг, 8.6 хувийг эсэг сүүн бүтээгдэхүүн, 4.2 хувийг бусад бүтээгдэхүүн эзэлж байна. Бүх төрлийн сүүн бүтээгдэхүүн дотроос хэрэглэгчид уухад бэлэн шингэн сүү, хуурай сүүг хамгийн ихээр сонгож хэрэглэдэг бол, таргийг илүүд үздэг хүмүүсийн эзлэх хувь харьцангуй бага байна.

Дэлхийн хэмжээнд, ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт ерөнхийдөө өсөх хандлагатай байгаа хэдий ч өөр өөр нэрийн бүтээгдэхүүний борлуулалтын өсөлтийн хувь харилцан адилгүй байна. Эдгээрийн дотроос, ингэний сүүн эсэг бүтээгдэхүүн болон ингэний цэвэр сүүний борлуулалтын жилийн дундаж өсөлт харьцангуй удаан буюу тус тус 3.7 хувь, 3.9 хувьтай байна. Ингэний сүүн зайрмагийн борлуулалт хамгийн өндөр өсөлттэй буюу 5 хувьтай байна. Үүний гол шалтгаан гэвэл, ингэний сүүний уургийн баялаг агууламж, өвөрмөц амт нь ингэний сүүн зайрмагийн амтыг илүү тодотгож өгдөг, ингэний хуурай сүүг хадгалах, авч явах, хүнсэнд хэрэглэхэд амар хялбар байдаг тул дэлхийн өнцөг булан бүрд буй хэрэглэгчдийн таашаалд нийцдэг. Энэ бүтээгдэхүүний борлуулалтын жилийн өсөлт 4.6 хувьд хүрээд байна.

4.3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

4.3.1. Хэрэглэгчийн хүсэл сонирхол ба сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлын төлөв чанарын төлөө төлөхөд бэлэн хамгийн дээд үнэ буюу төлөх хүсэл эрмэлзэл.

Олон эрдэмтэн судлаачид судалгаагаа сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлын төлөв чанарыг судлахаас эхлүүлдэг. Бээжин, Хэбэйгийн хэрэглэгчид сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг чухалчлах үүднээс олонд танигдсан буюу алдартай брэндийн сүүн бүтээгдэхүүнийг супермаркет, дэлгүүрээс худалдан авахад бэлэн байдаг. Хотын айл өрхүүд эдгээр бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын баталгаатай, удаан хадгалах боломжтой гэж үздэг учраас супермаркетаас сүүн бүтээгдэхүүн авахыг илүүд үздэг. Хэйлунзян буюу Хар мөрний хэрэглэгчид НАССР буюу Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын гэрчилгээтэй сүүн бүтээгдэхүүнд ихээр итгэдэг ч энэ талаарх ойлголт мэдлэг бага, үүний төлөө өндөр төлөх хүсэлгүй байдаг.

Бээжингийн хэрэглэгчдийн 82.7 хувь нь дотоодын хүүхдийн тэжээлийн хуурай сүүний брэндүүдтэй харьцуулахад гадаадын хүүхдийн тэжээлийн хуурай сүүг илүү аюулгүй гэж үздэгтул гадаадын брэнд бүтээгдэхүүнийг худалдан авах хүсэлтэй байна.

БНХАУ-ын хэрэглэгчид Засгийн газраас баталгаажуулсан хэт өндөр температурт шуурхай ариутгасан (UHT) сүүн бүтээгдэхүүн зэрэг хүнсний бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хангахын тулд өндөр үнэ төлөхөд бэлэн байна. Нанжин хотын хэрэглэгчдийн 91.5 хувь нь хүнсний аюулгүй байдалд илүү их анхаарал хандуулдаг бөгөөд тэдний 69.8 хувь нь хадгалах хугацаа болон үйлдвэрлэсэн огноог хүнсний аюулгүй байдлын үндсэн үнэлгээ болгон авч үздэг. Эцэг эхчүүд Засгийн газрын ЧАБ (QS)-ын гэрчилгээтэй бүтээгдэхүүн, шим тэжээлийн шошготой бүтээгдэхүүн болон импортын бүтээгдэхүүнд өндөр төлбөр төлөхөд бэлэн байгаа бөгөөд хэрэглэгчид аюулгүй байдлын баталгаатай сүүн бүтээгдэхүүнд 57.6 хувийн нэмэлт төлбөр төлөхөд бэлэн байна.

4.3.2. Хэрэглэгчийн хүсэл сонирхол ба сүүн бүтээгдэхүүний функциональ шинж чанар, түүнийг тэжээллэг чанартай болгон баяжуулсны төлөө төлөхөд бэлэн хамгийн дээд үнэ.

Гадаадын олон эрдэмтэн судлаачид сүүн бүтээгдэхүүний функциональ шинж чанар, тэжээллэг чанартай холбоотой хэрэглэгчдийн хүсэл сонирхол, түүнд төлөх хамгийн дээд үнийн талаар судалжээ. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд байгалийн амттай шингэн сүүг илүүд үздэг, ахмад настнуудтай харьцуулахад залуучууд амтлаг сүүг илүүд үздэг, ахмадууд шингэн сүү худалдаж авахдаа өөх тосны агууламжийг илүү анхаарч үздэг бол, өндөр орлоготой хэрэглэгчид өөх тос багатай шингэн сүүг илүүд үздэг бөгөөд үүнийг өндөр үнээр худалдан авахад бэлэн байдаг ажээ. Хүүхдэд зориулсан шингэн сүүг худалдан авахдаа эцэг эхчүүдийн 73 хувь нь шингэн сүүний амтыг, 43 хувь нь шингэн сүүний шимт чанарыг харгалzan үздэг ба эх, эцэг эхчүүдийн 98 хувь нь брэндэд анхаарал хандуулдаг бол, 93 хувь нь брэнд болон амтыг нь харгалzan үздэг байна. Тарагны төлөв чанаруудын дотроос хэрэглэгчид эрүүл мэндтэй холбоотой шинж чанар, амтыг нь, эрүүл мэндэд нөлөөтэй шинж чанаруудтай харьцуулахад бүтээгдэхүүний найрлага, үнэ, брэнд, хэрэглэхэд дөхөм байдал, шим тэжээлийг илүүтэй чухалчилдаг байна. Хэбэй мужийн хотын хэрэглэгчид сүүн бүтээгдэхүүн худалдаж авахдаа шим тэжээлийг, үүний дараа брэнд, үнэ, сав баглаа боодлын үзэмжийг чухалчилж байна.

4.3.3. Органик сүүн бүтээгдэхүүн зэрэг бусад төлөв чанаруудын талаарх хэрэглэгчдийн хүсэл сонирхол

Хэрэглэгчдийн дунд, мөшгөлтийн гэрчилгээтэй сүүн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өндөр байна. Судалгаанд оролцогчид мөшгөлт хийгдээгүй сүүн бүтээгдэхүүнтэй харьцуулахад мөшгөлт хийгдсэн сүүн бүтээгдэхүүнд өндөр үнэ төлөхөд бэлэн байна. БНХАУ дахь хэрэглэгчид, чанарын гэрчилгээтэй бүтээгдэхүүнтэй харьцуулахад органик болон ногоон гэрчилгээтэй сүүн бүтээгдэхүүнийг илүүд үзэж байна. Тайван улсын хэрэглэгчид БХААС (CAS)-ын дагуу олгосон органик бүтээгдэхүүний гэрчилгээтэй буюу органик гэдэг нь баталгаажсан шинэ сүү худалдан авахад илүү бэлэн байгаа бөгөөд жил бүр органик бүтээгдэхүүний гэрчилгээтэй сүүн бүтээгдэхүүн (CAS)-д дунджаар 21.95 доллар нэмж төлөхөд бэлэн гэсэн байна. Шаньдуны хэрэглэгчдийн тухайд, ерөнхийдөө бол, органик сүүн бүтээгдэхүүнд итгэдэг. Дотоодын брэндүүд болон дотоодын гэрчилгээтэй бүтээгдэхүүнтэй харьцуулахад, хэрэглэгчид Европын холбооны брэндүүд болон Европын холбооны баталгаажуулалтад итгэх итгэл өндөр байна.

5

БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

- 
- 5.1. БНХАУ-ЫН ингэний сүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү
 - 5.2. Ингэний сүүний хэрэглээ (эрэлт, нийлүүлэлт)-ний 2022-2027 оны төсөөлөл ба өсөлтийн хувь
 - 5.3. Гол сорилт бэрхшээлүүд

5.1. БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ЗӨРҮҮ

21 дүгээр зуунаас хойш ингэний сүүн бүтээгдэхүүний дэлхийн хэмжээний эрэлт хэрэгцээ хурдацтай өсөх хандлагатай байна. НҮБ-ын ХХААБ-ын мэдээллээр, 2021 онд дэлхийн хэмжээнд ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 12362 сая ам.долларт, 2016-2021 оны жилийн дундаж өсөлт 4.6 хувьд хүрээд байна.




Зураг 26. Ингэний сүүн бүтээгдэхүүний дэлхийн нийт борлуулалт

2021 онд БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийт борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 751.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн 5 жилийн хугацаанд даруй 35.1 хувиар өссөн бөгөөд жилийн дундаж өсөлт 5.5 хувьд хүрлээ. Зах зээлийн эрэлтийн өсөлт Европ, Африк, Ази тивийн бусад орнуудтай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна. Ирэх таван жилд дотоодын эрэлт хэрэгцээ өндөр байхаар байгаа нь БНХАУ-ын зах зээлд ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт өсөх орон зайг нэмэгдүүлж, ингэний сүүн бүтээгдэхүүний хэрэглээ үргэлжлэн нэмэгдэнэ гэж тооцоолоод байна. 2027 он гэхэд импортын хэрэгцээ 767 мянган тоннд хүрнэ гэсэн тооцоо бий. БНХАУ-тай хиллэдэг Монгол Улсын ингэний сүүний гарц өндөр, байгаль, газар зүйн давуу талтай, ингэний сүүний өнөөгийн үнэ өндөр, ингэний сүүний экспорт нь Монгол Улсын тэмээний аж ахуйн хөгжилд шинэ өсөлтийг бий болгоно.

Иргэдийн амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр сүүн бүтээгдэхүүний хэрэглээ эрс нэмэгдэнэ хэмээн мэргэжилтнүүд таамаглаж байна. Өнөөгийн байдлаар, ингэний сүүний дотоодын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хооронд тодорхой зөрүү байсаар байгаа бөгөөд дотоодын зах зээлийн хэрэгцээг хангахын тулд жил бүр ихээхэн хэмжээний сүүн бүтээгдэхүүн импортлох шаардлагатай байна. Ингэний сүүний хэрэглээ хурдацтай өсөхийн хэрээр шинэ сүүний эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй байдал урт удаан хугацаанд үргэлжлэх төлөв ажиглагдах боллоо. Ингэний сүүн бүтээгдэхүүнийг шим тэжээл, чанар сайтай, эрүүл мэндэд тустай гэж ойлгож, хэрэглэхийг оролдох болсон хэрэглэгчдийн тоо улам бүр нэмэгдэж, зах зээлийн цар хүрээ өргөжиж байгаа нь дэлхийн ингэний сүүний салбарын хөгжлийг тасралтгүй



хурдасгаж байна. Хэдийгээр, тэмээн сүргийн тоо толгой өсөж байгаа ч, ингэний сүүний үйлдвэрлэл багахан хэмжээтэй байгаагаас үүдэн эрэлт өндөр хэвээр, дотоодын бүтээгдэхүүний нийлүүлэлт хомс байгаа тул импортын орон зай ихтэй хэвээр байна. БНХАУ нь дэлхийн хамгийн их буюу 1.4 тэрбум хүн амтай, асар том хэрэглэгчдийн зах зээлтэй орон. Судалгаанаас харахад, БНХАУ-д дор хаяж 10 сая хүн онцгой цагаан идээ буюу сүүн бүтээгдэхүүн, тэр дундаа ингэний сүү хэрэглэх хүсэл сонирхолтой байна. Нэг хүнд хоногт 0.6 кг ингэний сүүн бүтээгдэхүүн ногдож байгаад үндэслэн тооцоолж үзвэл, одоогийн дотооддоо үйлдвэрлэсэн ингэний сүү (жилд 30000 тонн) 600000 хүнд л хүрэлцэхүйц байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад хол байгааг харуулж байна. Ингэний сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд сурталчлан таниулах тусам ингэний сүүний импортын эрэлт өсөх хандлагатай байгаа бөгөөд 2027 он гэхэд импортын хэрэгцээ 767 мянган тоннд хүрэх төлөвтэй байна



Зураг 27. БНХАУ-ын ингэний сүүний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү

21 дүгээр зуунаас эхлэн, ингэний сүүний үйлдвэрлэл хөгжиж, шинэчлэгдэж, хэрэглэгчдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэн, хүнсний хэрэглээндээ зориулж зардал гаргах чадавх сайжирсаар байгаа нь ингэний сүүний дэлхийн эрэлт хэрэгцээ хурдацтай өсөхөд түлхэц үзүүлжээ. НҮБ-ын ХХААБ-ын мэдээлснээр, 2021 онд дэлхийн хэмжээнд ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 12,362 сая ам.доллар байсан бөгөөд 2016-2021 оны хооронд жилд дунджаар 4.8 хувиар өсжээ. 2021 онд БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний нийт борлуулалт (үйлдвэрлэлийн үнээр) 751.3 сая ам.долларт хүрч, 2016 онтой (556 сая ам.доллар) харьцуулахад даруй 35.1 хувиар өссөн бөгөөд жилийн дундаж өсөлт 5.5 хувьд хүрсэн байна. Дотоодын ингэний сүүн бүтээгдэхүүний жилийн өсөлтийн хувь дэлхийн нийт ингэний сүүн бүтээгдэхүүний өсөлтөөс хамаагүй өндөр бөгөөд БНХАУ дахь ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалт дэлхийн нийт ингэний сүүн бүтээгдэхүүний борлуулалтын 6 хувийг эзэлж байна (Зураг 28-д үзүүлэв). Түүнчлэн ингэний сүүн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн эрэлтийн өсөлтийн хувь Европ, Африк, Азиийн бусад орнуудынхаас илт өндөр байна.



Зураг 28. Дэлхийн болон БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦУУЛАЛТ, 2021

Монгол Улс нь дэлхийн хамгийн олон хос бөхт тэмээтэй орон. Ингэний сүүний үйлдвэрлэлийн хувьд байгалийн давуу талтай. Монголын малчдын 64.7 хувь нь тэмээний аж ахуй эрхэлдэг бөгөөд тэдгээр нь Монгол Улсын нийт хүн амын 5.4 хувийг эзэлдэг. Говь нутгийн малчдын эдийн засгийн гол орлого нь тэмээний аж ахуйгаас ордог орлого бөгөөд сүүлийн жилүүдэд байгаль, цаг агаарын нөхцөл байдал, тээвэрлэлттэй холбоотой хүндрэл, бусад шалтгааны улмаас экспортын зах зээлээ хараахан нээж чадаагүй байна.


БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН НЬ БНХАУ-ЫН ИНГЭНИЙ СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ЗАН ТӨЛӨВИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ, МОНГОЛ УЛСЫН ИНГЭНИЙ СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТОД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ, ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭ, НЭР ТӨРЛИЙГ ТОДОРХОЙЛЖ, ИНГЭСНЭЭР БНХАУ-ЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН ХҮСЭЛ СОНИРХОЛ, ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭГ ИЛҮҮ САЙН ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ЗАРИМ ЗААВАРЧИЛГААГААР ХАНГАЖ БУЙ ХЭРЭГ ЮМ. ТҮҮНИЙ САЦУУ, БНХАУ-ЫН ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ХИЙСЭН ЭРЭЛ ХАЙГУУЛ, ТУРШЛАГА НЬ МОНГОЛ УЛСЫН ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН ХӨГЖИЛД ЧУХАЛ ХЭРЭГТЭЙ, АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ МЭДЭЭЛЭЛ БОЛЖ ЧАДНА.

5.2. ИНГЭНИЙ СҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ (ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ)-НИЙ 2022-2027 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ БА ӨСӨЛТИЙН ХУВЬ

Ингэний сүүний үйлдвэрлэл, хэрэглээ эртний түүхтэй. Шинэ эрин үед ингэний сүүн бүтээгдэхүүний шинэ функц буюу үйлчлэх чанар, баялаг шим тэжээлт чанарыг олж мэдсэнээр дотоодын эрэлт хэрэгцээ хурдацтай өсөж байна. Хэрэглээ өсөхийн хэрээр сүүн бүтээгдэхүүн энгийн иргэдийн хоол тэжээлийн хэрэгцээ болсон. Хуурай сүүний үйлдвэрт олон мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд өрсөлдөөн ч ширүүн байдаг. Уг салбар өөрчлөн зохион байгуулагдахад ойрхон байна. Зах зээлийн асар том бялуутай тулгарсан дотоод, гадаадын хуурай сүүний брэндүүд



нөөцийг шүүрч авахын төлөө өрсөлдөж, үүний үр дүнд зах зээлд олон тооны хуурай сүүний үйлдвэрүүд, холимог брэндүүд, эмх замбараагүй томьёолол буюу жор гарч ирснийг олон мянган цэрэг, ширүүн өрсөлдөөнтэй зүйрлэж болох бөгөөд энэхүү нөхцөл байдал салбарын хөгжилд өөрчлөлт буюу эргэлт хийх явцыг хурдасгаж байна. Ингэний сүүн бүтээгдэхүүн нь тэжээллэг чанар сайтай, олонд танигдсан учраас зах зээлийн орон зайд том, өрсөлдөөний дарамт бага байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд зах зээлд нэвтрэх сайхан боломж юм. Тэд нэг алхам урагшлахад л ингэний сүүний салбарын хөгжлийн салхийг хагалж, аж үйлдвэрийн хөгжлийн загварыг гаргах үйл явцыг түргэтгэж чадна. Ингэний сүүний өнөөгийн зах зээлийн хөгжлөөс харвал, 2022-2027 онд БНХАУ-ын ингэний сүүний хэрэглээний эрэлт эрс нэмэгдэх төлөвтэй байна. Ингэний сүүний хэрэглээ, өсөлтийн хувийг Зураг 29-т үзүүллээ. Иймд, ирээдүйн хэрэглэгчдийн хэрэгцээг хангахын тулд үргжлийн ажлыг өргөжүүлэх, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эс бөгөөс гадаадаас ингэний сүү импортлох шаардлагатай байна.



Зураг 29. 2022-2027 онд улсын хэмжээний ингэний сүүний хэрэглээ, хэрэглээний өсөлтийн төсөөлөл

5.3. ГОЛ ГОЛ СОРИЛТ БЭРХШЭЭЛҮҮД

Бага хэмжээгээр үйлдвэрлэгддэг хуурай сүүний нэг болох ингэний сүүг шим тэжээлээр баялаг учраас, сүүлийн жилүүдэд улам олон хэрэглэгчид найр тавьж ирсэн хэдий ч сүүний эх үүсвэр хомс, өндөр үнэтэй зэрэг нь олон хэрэглэгчдэд боломж олгохгүй байдалд хүргэж байна. Оршин суугчид ингэний сүүгдахин таашааж эхэлснээр сүүний үйлдвэрүүд хөрөнгө оруулалт хийж, олон төрлийн ингэний сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хуурай сүүний салбарыг эзлэхээр өрсөлдөж байна. Ирээдүйн асар том зах зээл болон томоохон зах зээлийг бий болгоход учрах хүндрэл бэрхшээл эсвэл сүүний үйлдвэрүүдэд тулгарч буй томоохон сорилт бэрхшээлүүд хоорондоо зөрчилдөөнтэй байна.

Эдүгээ, ингэний сүүний салбарыг хөгжүүлэхэд сорилт ч тулгарч байна, боломж ч оршин байна. Нэг талаар үүнд эргэлзэх дуу хоолой нэмэгдэж байгаа ч, нөгөө талаар энэ нь ингэний сүүний үйлдвэрлэлийг стандартчилах асуудлаар хэлэлцэж, салбар эргэлт хийх шат руугаа орж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг илүү чадвартай, туршлагатай үйлдвэрүүд товойн гарч ирнэ гэсэн үг. Сүүний томоохон үйлдвэрүүд зах зээлд нэвтрэн орж ирснээр ингэний сүүний үйлдвэрүүд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ болон өөрсдийн хүч чадалд нийцүүлэн өөрийн гэсэн брэнд нөлөөг бий болгож, улмаар зах зээлийн өрсөлдөөнд давуу тал олж авна.

5.3.1. Ингэний сүүн бүтээгдэхүүний чанар

Ингэний сүү нь ингэний шинэхэн сүүний шим тэжээлийг дээд зэргээр хадгалсан дээд зэргийн чанартай ингэний сүүн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангадаг, тэжээллэг чанар сайтай, байгалийн цэвэр олон үйлдэлт ногоон органик хүнс хэмээн үнэлэгдэж ирсэн. Гэхдээ, бэлчээрийн ингэний сүү, малын тэжээлээр бордсон ингэний сүүний шим тэжээлийн найрлага хоорондоо зарим талаар ялгаатай. Малын тэжээл нь шим тэжээлээр баялаг бөгөөд шаардлагатай орцуудыг тэмээнд тохируулан нэмж өгдөг бөгөөд ингэснээр, ингэний сүүний гарц илүү, түүхий сүүний чанар өндөр байдаг бол бэлчээрийн тэмээ тодорхой хэмжээнд хязгаарлагдмал байдаг тухайн газар нутгийнхаа өвс ургамлаар тэжээгддэг. Иймд, чанарын тогтолцоо, ингэний сүүний уураг, тослог, соматик эсийн тоо, бактерийн нийт тоо зэрэг гол үзүүлэлтүүдийг улирал тутам хянаж, ингэснээр ингэний сүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар ингэний түүхий сүү худалдан аваадаа үндэсний болон тухайн орон нутгийн стандарт, үйлдвэрлэлийн стандартыг чанд мөрдөж, сүүний үйлдвэр, фермер, хоршоо зэрэг үндсэн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийг цаашид стандартчилж, тэдгээрийг удирдамж чиглэлээр хангадаг байх шаардлагатай. Ийм арга замаар БНХАУ-ын ингэний сүүний үйлдвэрлэлийн эрүүл, тогтвортой хөгжлийг дэмжих боломжтой.

5.3.2. Ингэний сүүн бүтээгдэхүүний үнэ

Ингэний сүүг «цөлийн цагаан алт» гэж нэрлэх болсон нэг шалтгаан нь шим тэжээлээс гадна түүний өндөр үнэтэйд оршдог. Ингэний саалийн хугацаа богино, сааль саахад тавигдах шаардлага өндөр зэрэг нь ингэний сүүний үйлдвэрлэлийн өртгийг эрс нэмэгдүүлдэг. БНХАУ-д ингэний түүхий сүүний үнэ бусад төрлийн түүхий сүүнээс 10 дахин өндөр байдаг. Ажиллах хүчний зардал, тэжээлийн үнэ, уур амьсгалын өөрчлөлт, эрэлт хэрэгцээ болон бусад олон хүчин зүйлийн нөлөөгөөр түүхий сүүний үнэ жилээс жилд өссөөр байгаа тул дараалсан хэд хэдэн боловсруулалтын дараа ингэний сүү илүү үнэтэй болдог. Гэтэл үнэ 1 хувиар өсөхөд хэрэглэгчдийн сарын дундаж хэрэглээ 0.56 хувиар нэмэгддэг бөгөөд ингэний сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд ингэний сүүн бүтээгдэхүүний талаар сурталчлан таниулах, нэр хүндийг нь дээшлүүлэх явдал нэн чухал, ингэснээр улам олон хэрэглэгчид ингэний сүүний шим тэжээлийн үнэ цэнийг ойлгож, брэндийн талаарх мэдлэг ойлголт нь ч дээшилнэ.

“CBN” бизнесийн мэдээллийн төв болон Тмолл Хүнс компанийн хамтран гаргасан “Насанд хүрэгчдэд зориулсан хуурай сүүний үйлдвэрлэлийн 2021 оны чиг хандлагын тайлан»-д дурдсанаар, цахим худалдаа нь дэлгүүрийн борлуулалттай харьцуулахад түрээсийн болон дэлгүүрийн үйл ажиллагааны зардлын бууралт, хямд үнэ, хэрэглээнд дөхөмтэй байдал, хурдан шуурхай үйлчилгээ зэргээс үүдэн ингэний хуурай сүүний борлуулалтын гол суваг болж чадсан байна. 2021 онд ингэний цэвэр хуурай сүүний борлуулалт хурдацтай буюу даруй 300 гаруй хувиар өсжээ.



БНХАУ-ын ингэний сүүн бүтээгдэхүүний хэрэглээнд хараажаар оршин суугчдын орлогын түвшин, боловсролын түвшин, хүн амын тоо, бүтэц, хотжилтын түвшин нөлөөлдөг бөгөөд энэ нь сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалтай ихээхэн хамаарлтай байна. Хэрэглэгчид сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэж байх үедээ түүний функциональ чанар, шим тэжээлийн баяжуулалт зэрэг шинж чанарт илүү анхаардаг бол, үүний дараа сүүн бүтээгдэхүүний тэжээллэг чанар, амт, брэнд, өнгө үзэмж, хэрэглэхэд дөхөм байдал зэрэгт мөн анхаарлаа хандуулдаг. Ингэний сүүн бүтээгдэхүүн нь тэжээллэг чанар, амт чанар сайтай байдгаараа улам олон хэрэглэгчдэд танигдсаар байна. Тэгвэл одоо, түүхий эдийн өртөг зардлыг бууруулж, үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож, үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгон, бүтээмжийг дээшлүүлж, борлуулалтын сувгийг оновчтой болгон, тэмээ үргүүлгийг нэмэгдүүлэх замаар зардлаа бууруулах шаардлагатай бөгөөд ингэснээр улам олон хэрэглэгч ингэний өндөр чанартай сүүн бүтээгдэхүүнийг таашаан хэрэглэх боломжтой болох юм.

5.3.3. Ингэний сүүн бүтээгдэхүүний төрлүүд

Хэрэглэгчид насанд хүрэгчдэд зориулсан хуурай сүүг эрүүл мэндийн хэрэгцээндээ зориулан худалдан авдаг бөгөөд ингэний цэвэр сүү нь шим тэжээлээр баялаг, хүний биеийн хэрэгцээг хангах чадвартай учраас хэрэглэгчдийн дунд тодорхой хэмжээгээр танигдсан байдаг. Хэрэглэгчдийн илүү төрөлжсөн, босоо хэрэглээний эрэлт хэрэгцээг хангахын тулд ингэний цэвэр сүүн бүтээгдэхүүнд суурилсан бүрэн тослогтой эсгэсэн цэвэр хуурай сүү, ингэний исгэлэн сүүн шахмал, ингэний пробиотик сүүн шахмал болон хэрэглэгчдийн хэрэгцээг бүх талын, төрөлжүүлсэн байдлаар хангахын тулд гиперлипидемитэй эсвэл цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах хэрэгцээтэй хүмүүст зориулж өөх тос бууруулах уураг ихтэй ингэний хуурай сүүг үйлдвэрлэлд нэвтрүүлээд байна.

5.3.4. Бүтээгдэхүүн хэрэглээний хувилбарууд

Хэрэглээний хувилбаруудад голчлон хувилбарт суурилсан бүтээгдэхүүний савлагааны дизайн, хувилбарт суурилсан бүтээгдэхүүнд анхаарал татагдах гол санаа буюу уран сэтгэмжийг тодруулж өгөх зэрэг багтана. Хэрэглээний тодорхой хувилбар байхгүй бол хэрэглэгчид бүтээгдэхүүн худалдан авах шалтгаан байхгүй болно. Иймд, брэнд төлөвлөлтийн ажлаа сайн хийж, супер ганц бүтээгдэхүүн бий болгож, энэ хоёр цөмийг тойрон, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өрсөлдөх давуу талыг бий болгох нь зүйтэй. Бүтээгдэхүүн, үнэ, борлуулалтын суваг, сурталчилгаа болон маркетингийн бусад элементүүд буюу язгуур хэсгүүд нь эцсийн эцэст бизнесийн үйлчилгээнд зориулагдсан байдаг бөгөөд хэрэв тогтвортой давуу талыг бий болгож чадахгүй бол эдгээр үзүүлэлтүүд зах зээлд өрсөлдөх чадвараа алдах болно.

6

ИМПОРТЫН БОДЛОГО

- 
- 6.1. Ингэний сүүн бүтээгдхүүнд мөрдөгддөг БНХАУ-ын стандарт ба дэг журам
 - 6.2. Ложистикт тавигддаг даатгалын гэрээний нэмэлт үүргийн шаардлага
 - 6.3. Экспортод учирч болзошгүй эрсдэлүүд ба тэдгээрийг даван туулах арга зам
 - 6.4. Монгол Улсаас БНХАУ руу ингэний сүү экспортлох маршрут



6.1. ИНГЭНИЙ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТОД МӨРДӨГДӨЖ БҮЙ БНХАУ-ЫН СТАНДАРТ БА ДЭГ ЖУРАМ

Хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход БНХАУ-ын Гаалийн газрын гадаад худалдааны бараанд хяналт шалгалт хийх арга хэмжээ, БНХАУ-ын импорт, экспортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын менежментийн арга хэмжээ зэрэг БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын арга хэмжээ, дүрэм журмыг мөрдлөг болгох ёстой бөгөөд мөн импортын хүнсний бүтээгдэхүүн нь стандарт, дүрэм, журамд нийцсэн байх ёстой. БНХАУ-д ингэний сүүн бүтээгдэхүүнтэй холбоотой дараах 19 салбарын стандарт, орон нутгийн стандарт, бүлгийн стандартууд мөрдөгддөг:

- БНХАУ-ын сүүний салбарын стандарт Ингэний хуурай сүү (RHB903-2017)
- БНХАУ-ын сүүний салбарын стандарт Ингэний түүхий сүү (RHB900-2017)
- БНХАУ-ын сүүний салбарын стандарт Ингэний эсгэсэн сүү (RHB902-2017)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний хуурай сүү (DBS15/016-2019)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний хуурай сүү (DBS15/015-2019)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний ариутгасан сүү (DBS15/017-2019)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний хуурай сүү (DBS65/014-2017)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний түүхий сүү (DBS65/010-2017)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний ариутгасан сүү (DBS65/012-2017)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний өтгөрүүлсэн сүү (DBS65/011-2017)
- Орон нутгийн хүнсний аюулгүй байдлын стандарт Ингэний эсгэсэн сүү (DBS65/013-2017)
- Бүлгийн стандарт Ингэний хуурай сүү (T/CAAA011-2019)
- Бүлгийн стандарт Ингэний эсгэг хуурай сүү (T/CAAA012-2019)
- Бүлгийн стандарт Ингэний түүхий сүү (T/CAAA007-2019)
- Бүлгийн стандарт Ингэний өтгөрүүлсэн сүү (T/CAAA009-2019)
- Бүлгийн стандарт Ингэний эсгэсэн сүү (T/CAAA010-2019)
- Бүлгийн стандарт Ингэний ариутгасан сүү (T/CAAA008-2019)
- Бүлгийн стандарт Өндөр хэмд ариутгасан ингэний сүү (T/IMAS035-2022)
- Бүлгийн стандарт Ингэний шинэхэн сүүг цуглуулахад баримтлах журам (T/IMAS046-2022)

Түүнчлэн, импортын савласан хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтүүд нь хятад хэл дээрх шошготой байх бөгөөд хуульд заасан зааврыг мөн хятад хэл дээр бичсэн байхыг шаарддаг. Шошго болон заавар нь хууль болон БНХАУ-ын холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны дүрэм журам, үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлагад нийцсэн байх бөгөөд хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, дотоодын төлөөлөгчийн нэр, хаяг, холбоо барих хаягийг зааж өгсөн байх ёстой. Энэхүү зүйл заалтад нийцээгүй, хятад хэл дээрх шошго, зааваргүй урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүнийг импортлохыг хориглодог.

Импортын хүнс, хүнсний нэмэлт болон хүнсийн холбоотой бүтээгдэхүүн нь БНХАУ-ын үндэсний хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн байх ёстой. Импортоор оруулж ирж буй хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтийг Импорт, экспортын барааны хяналтын тухай хууль болон захиргааны горим журмын дагуу улсын хилээр нэвтрүүлэх, гаргахад хяналт тавьдаг хяналтын болон хорио цээрийн хяналтын байгууллагын шалгалтад хамруулдаг. Импортын хүнс, хүнсний нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх, гаргахад хяналт тавих үүрэгтэй хяналтын болон хорио цээрийн албанаас тавьдаг шаардлагын дагуу тохирлын гэрчилгээ дагалдах ёстой. Нийтдээ хүнсний 13 ерөнхий стандарт бий.

Хүснэгт 3. Зохицуулалт, хяналтын аргууд

Серийн дугаар	Стандартын нэр	Стандартын дугаар
Ерөнхий стандарт: 13 стандарт		
1	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хүнсэнд агуулагдах микотоксиний зөвшөөрөгдөх дээд хэмжээ	GB2761-2017
2	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хүнсэнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	GB 2762-2022
3	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хүнсэнд агуулагдах пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	GB 2763-2021
4	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хүнсэнд агуулагдах малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	GB 31650-2019
5	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Савласан хүнсний бүтээгдэхүүн дэх эмгэг төрүүлэгч бактерийн хязгаар	GB 29921-2021
6	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Шууд хэрэглэхэд бэлэн их хэмжээний тусдаа савлагаагүй хүнсний бүтээгдэхүүн дэх эмгэг төрүүлэгч бактерийн хязгаар	GB 31607-2021
7	Хүнсний нэмэлтийг хэрэглэх үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт	GB 2760-2014
8	Хүнсний бүтээгдэхүүнд хүрэлцдэг материал болон бүтээгдэхүүний нэмэлтийг хэрэглэх хүнсний аюулгүй байдлын үндэсний стандарт	GB 9685-2016
9	Хүнсний шим тэжээлийг баяжуулдаг бодисын үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт	GB 14880-2012
10	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтын ерөнхий дүрэм	GB 7718-2011
11	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн шошгололтын ерөнхий зарчим	GB 28050-2011
12	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хоолны тусгай дэглэмийн зориулалттай урьдчилан савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололт	GB 13432-2013
13	Үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт Хүнсний нэмэлтийг шошголох ерөнхий дүрэм	GB 29924-2013



6.2. ЛОГИСТИКТ ГЭРЭЭНЭЭС ГАДУУРХ ХАРИУЦЛАГЫН (ЕСО) ДААТГАЛЫН ЗААЛТЫГ ШААРДАХ

Нийгмийн эдийн засаг үргэлжлэн хөгжихийн хэрээр хүмүүс үйлдвэрлэл болон логистикийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үр өгөөжид улам бүр анхаарал хандуулж, харин эдийн засгийн хөгжлөөс үүдсэн байгаль орчны асуудал, тогтвортой хөгжлийн асуудлыг үл тоомсорлох хандлагатай байна. Олон хүн логистик нь эдийн засгийн хөгжлийг дэмжинэ гэж үздэг хэдий ч, логистик, тэр дундаа аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн ашиг сонирхлоос үүдэлтэй экологийн орчны өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг харгалzan үзэх нь ховор, экологийн логистикийг бий болгох дотоод хүсэл эрмэлзэл дутмаг байна. Угтаа бол, логистик нь хаягдал хий, дуу чимээгээр байгаль орчныг ноцтой бохирдуулдаг, үүнтэй зэрэгцээд тулш, эрчим хүч их зарцуулдаг салбар юм. Иймд логистикийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, үр дүнтэй арга хэмжээ авах, урамшууллын механизмыг бий болгож сайжруулах, экологийн логистикийн тогтолцоог бүрдүүлэх нь орчин үеийн логистикийн хөгжлийн чухал асуудал юм. Экологийн логистикийн зорилго нь байгаль орчин, логистик эдийн засгийн хөгжлийн хоорондын тэнцвэрт байдлыг хангаж, үр дүнд хүргэх, логистикийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хязгаарлах, логистикийн ашиг тусыг нэмэгдүүлэхэд оршдог. Энэхүү логистикийн удирдлагын тогтолцоо нь эрүүл хэрэглээ, эдийн засгийн хамтын хөгжлийг дэмжих боломжтой. Экологийн логистик гэдэг нь байгаль орчин, эдийн засгийн хөгжлийн тэнцвэрт онцлон анхаарч, аж ахуйн нэгжийн логистикийн удирдлагын тогтолцоог ногоон хөгжлийн зарчимд нийцүүлэх чиглэл баримтлан хөгжүүлэх, байгаль орчны үүднээс логистикийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх тухай асуудал юм.

Олон улсын ачаа тээврийн даатгал гэдэг нь олон улсын тээвэрт бараа бүтээгдэхүүнд учирч болзошгүй хохирлын хариуцлагыг нэг тал нөгөө талдаа тодорхой төлбөр хураамж төлөх нөхцөлтэйгөөр хүлээхийг шаарддаг худалдааны үйлчилгээний нэг төрөл юм. Дэлхийд ачааны даатгалын тухай нэг загварын буюу нэгдсэн хууль гэж байдаггүй. Практикт, даатгагч болон даатгуулагчийн эрх, үүргийг улс орнуудын дотоодын хууль тогтоомж, хоёр талын байгуулсан даатгалын гэрээгээр тодорхойлж зохицуулдаг. 1995 онд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооноос баталсан Даатгалын тухай хууль (2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан), 1992 онд батлагдсан Далайн тухай хууль нь БНХАУ-ын ачаа тээврийн даатгалын үндсэн эрх зүйн үндэс болж өгдөг.

1981 оны 1-р сарын 1-ний өдөр шинэчлэн батлагдсан БНХАУ-ын Ардын даатгалын компанийн хуурай замын ачаа тээврийн даатгалын нөхцөлийн дагуу үндсэн эрсдэлийг газрын тээврийн даатгал, хуурай замын тээврийн бүх эрсдэл гэж хуваадаг. Нэмэлт эрсдэлүүдэд хуурай замын ачааны дайны эрсдэл, хуурай газрын тээвэрлэлтийн хөргөлттэй ачааны даатгал ордог.

Холбогдох материалыг хавсаргасан болно.

6.3. ЭКСПОРТОД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМУУД

БНХАУ-ын социалист шинэчлэлт урагшилж, өөрчлөлт шинэчлэл болон нээлттэй байдал гүнзгийрснээр, БНХАУ-ын импортын худалдааг хөгжүүлэх гадаад таатай орчин бүрдэж, БНХАУ-ын импорт, экспортын худалдааны эдийн засгийн өсөлт аажмаар хурдсаж ирсэн. Гэсэн хэдий ч, бодит амьдрал дээр импортын худалдааг хөгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэл өндөр байгаагаас үүдэн импортын худалдаа эрхлэгчид эдийн засгийн ноцтой хохирол амсаж байна. Иймд, шинээринд импортын худалдаанд учирч буй эрсдэлийн үр нөлөө, урьдчилан сэргийлэх арга хэмжээний судалгааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Импортын үйл явцад дараах гол эрсдэл учирч байна. Үүнд:

1. Бүтээгдэхүүний стандартаас шалтгаалж чанарын асуудал үүсдэг тул ингэний сүүн бүтээгдэхүүн, ялангуяа шинэхэн сүү нь хадгалах хугацаа бодино, хүйтэн хэлхээгээр тээвэрлэхэд тавигдах шаардлага өндөр байдаг. Монгол Улсад бэлчээрийн тэмээг ихээр үржүүлдгээс гадна чөлөөтэй нүүдэллэн мал малладаг малчид олон байдаг. Ингэний сүүг цуглуулах явцад хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой ариун цэвэр, эрүүл ахуйн чанарын асуудал үүсэж магадгүй бөгөөд энэ нь томоохон сорилт бэрхшээл учруулна. Түүхий эдийн чанар мөн жигд бус байх зэрэг асуудал гарч болно.

БНХАУ-ын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах хуулийг сайтар хэрэгжүүлж, хүнсний үйлдвэрлэл, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг бэхжүүлж, хяналт шалгалтыг шинжлэх ухаанч, үр дүнтэй хэрэгжүүлж, хяналтын үр ашиг, хүнсний аюулгүй байдлыг хангах чадварыг дээшлүүлэх зорилгоор, БНХАУ-ын Хүнс, Эмийн Захиргаанаас Хүнсний үйлдвэрлэл, үйл ажиллагааны эрсдэлийн түвшин буюу зэргийг зохицуулах хөтөлбөрийг боловсруулсан. Эдгээрийн дотроос сүү, сүүн бүтээгдэхүүн нь IV зэргийн эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд тооцогддог. Сүү, сүүн бүтээгдэхүүний статик эрсдэлт хүчин зүйлийн тоон үзүүлэлтүүдийг дор жагсаалаа:

Хүснэгт 4. Сүү, сүүн бүтээгдэхүүний эрсдэлийн зэрэг

Хүнсний бүтээгдэхүүний ангилал	Ангиллын нэр	Төрөл зүйлийн дэлгэрэнгүй мэдээлэл	Хүнсний бүтээгдэхүүний эрсдэлийн зэрэг	Оноо
Сүүн бүтээгдэхүүн	Шингэн сүү	1. Халааж боловсруулсан сүү	Өндөр (IV)	27.0
		2. Бэлтгэсэн буюу бэлэн сүү	Өндөр (IV)	27.0
		3. Ариутгасан сүү	Өндөр (IV)	26.0
		4. Эсгэсэн сүү	Өндөр (IV)	28.0
Сүүн бүтээгдэхүүн	Хуурай сүү	1. Бүтэн хуурай сүү 2. Тослогтой хуурай сүү 3. Хагас тослогтой хуурай сүү 4. Бэлтгэсэн хуурай сүү 5. Хуурай ангир шар уураг 6. Хуурай шар сүү	Өндөр (IV)	28.0

Сүүн бүтээгдэхүүн	Бусад сүүн бүтээгдэхүүн	<ol style="list-style-type: none"> 1. Өтгөрүүлсэн сүү 2. Цөцгий 3. Зөөхий 4. Усгүй зөөхий 5. Бяслаг 6. Боловсруулсан бяслаг 7. Тусгай нэрийн сүүн бүтээгдэхүүн 	High (IV)	26.5
-------------------	-------------------------	---	-----------	------

Ингэний сүү, сүүн бүтээгдэхүүний эрсдэлийн шинжилгээг сайжруулж, эрсдэлийн хяналтыг бэхжүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг санал болгож байна:

Түүхий сүүний болзошгүй аюулгүй байдлын аюул	Сүүн бүтээгдэхүүний эрсдэл, аюулгүй байдлын эрсдэл	Сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын эрсдэлд хяналт тавих
<ol style="list-style-type: none"> 1. Түүхий сүүний хольц болон гашилж муудах; 2. Түүхий сүүнд бичил биетний агууламж өндөр байх, хадгалалтыг уртасгах бодис нэмэх; 3. Түүхий сүүнд афлатоксин M1, антибиотик, гормон агуулагддаг. 	<ol style="list-style-type: none"> 1. Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулахдаа хадгалалтыг уртасгах бодисыг хязгаар, хэмжээнээс хэтрүүлэх; 2. Бүтээгдэхүүний уургийн агууламжийг нэмэгдүүлэхийн тулд гидролизжүүлсэн амьтны уургаар сүүний уургийг орлуулах; 3. Хугацаа нь дууссан, шаардлага хангагүй бүтээгдэхүүнийг дахин дахин боловсруулах. 	<ol style="list-style-type: none"> 1. Ингэ үргүүлэг болон түүхий сүү хүлээн авах хоорондын хамааралд тавих хяналтыг сайжруулах; 2. Аж ахуйн нэгжийн хяналтыг сайжруулж, бүтээгдэхүүний дээжид тавих хяналт, шалгалтыг чангатгаж, сүү үйлдвэрлэлийн эрүүл хөгжлийг дэмжих.

Зураг 30. Улсын хэмжээний ингэний сүүний хэрэглээ болон өсөлтийн төсөөлөл, 2022-2027 он

